

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



Төслийн зорилт хангагдаагүй, зарим багц ажлын гэрээ цуцлагдаж, төслийн явц удааширсан байна

АУДИТЫН СЭДЭВ: “УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 204.6 КМ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл

Утас: 263755, цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитын менежер Б.Саруул

Утас: 261805, цахим хаяг: saruulb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Болормаа

Утас: 261456, цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Аудитор М.Доржмаа

Утас: 261456, цахим хаяг: dorjmaam@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Утас: 261456, цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Г Аудитын тайлан баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төслийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн Засгийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэхийг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Зам, тээврийн сайдад тус тус зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Болормаа/-т үүрэг болгосугай.



Д.ЗАНДАНБАТ

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны
03. дугаар сарын 02-ны өдрийн 04 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

9016109
0819170396

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчил хариуцах	
		Байгууллага	Албан тушаалтан
1	“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын шинэчлэлтийн ажлын зураг төсөлтэй холбоотой материалыг архивын нэгж болгон хадгалах, төслийн удирдах хорооны чиг үүргийг гүйцэтгүүлэх, 2021 оны зам барилгын угсралтын бэлтгэл ажлыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээний “Ажлын даалгавар”-ын биелэлтийг дүгнэх, аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг хангаж ажиллах.		
Нийт дүн			



Аудитыг гүйцэтгэсэн:

Үндэсний аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын газар

Гүйцэтгэлийн аудитын газрын
захирал бөгөөд тэргүүлэх
аудитор

С.Оюунгэрэл

Аудитын менежер

Б.Саруул

Ахлах аудитор
Б.Болормаа

Аудитор
М.Доржмаа
Ш.Наранбаатар

Аудитын дүн, дүгнэлт,
зөвлөмжтэй холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж лавлах,
холбогдох саналаа өгөхийг хүсвэл
261456 дугаарын утас, 323266
дугаарын факсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-ын
www.audit.mn цахим хуудаснаас
үзнэ үү.

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

2021 оны 2 дугаар сар

АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	5
БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ САНХҮҮЖИЛТЭЭС ШАЛТГААЛЖ ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭХ АЖИЛ УДААШИРСАН БА ТӨЛӨВЛӨЛТИЙН БОЛОН ЗУРАГ ТӨСӨЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ШАТАНД ЗАРИМ ЗӨРЧИЛ ИЛЭРСЭН БАЙНА 6	
Авто замыг өргөтгэн шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болсон нь судалгаагаар тоогтоогдсон байна.....	6
Төслийг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн ч АХБ-ны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаар концессын зүйлийн жагсаалтаас хассан байна.....	7
Төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр шийдвэрээгүй, захиалагч байгууллага тодорхой бус байснаас ТЭЗҮ, зураг төсөл зохиох ажлыг гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгүүлсэн байна.....	8
Компанийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зураг төслийн зардлыг улсын төсвээс төлүүлэх шийдвэр гарсан байна	9
Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэрээс 2017 онд гүйцэтгэсэн ТЭЗҮ, судалгааны ажилд үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр зураг төсөөт нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг 2018 онд байгуулжээ	10
Барилга угсралтын 1 болон 2 дугаар шатанд баригдах замууд хийц, төлөвлөлтийн үзүүлэлтүүдээрээ өөр өөр байна.....	11
Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмаар оролцогч наарт тавигдах санхүүгийн шалгуур нь дотоодын компаниудын тендерт оролцох боломжийг хязгаарласан байна	14
Хамгийн бага унийн санал ирүүлснээр гүйцэтгэгчээр шалгарсан зарим оролцогчид гэрээг хэрэгжүүлэх чадваргүйгээс гэрээ цуцлагдсан байна	
Зам барилгын ажилд хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу зохион байгуулсан байна.....	17
БҮЛЭГ 2 ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ СУЛ, ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ХУГАЦААГ БОДИТОЙ ТОГТООГООГҮЙ, ГЭРЭЭ ЦУЦЛАГДСАН, ХУГАЦАА ДУУССАН, АЖЛЫН ЯВЦ УДААШИРСАН БАЙДАЛТАЙ БАЙНА.....	18
Төслийн удирдах хороо үйл ажиллагаа явуулаагүй, төслийн нэгжийн удирдлага зохион байгуулалт хангалтгүй, хүний нөөц дутуугаас зарим төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлээгүй байна	18
Зам барилгын үндсэн ажлыг богино хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж, гэрээ байгуулснаас чанаргүй ажил гүйцэтгэсэн байна..	21
2 болон 4 дүгээр багцын 90.5 км зам барих ажлын гэрээ цуцлагдсан байна.....	23
Зам, барилгын ажлыг 2020 оны 2 дугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хугацаандaa хэрэгжээгүй байна	26
Түр зам барих болон төслийн бэлтгэл шатны ажлуудыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн байна	28
ДҮГНЭЛТ:	29
ЗӨВЛӨМЖ:.....	30

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АХБ	Азийн хөгжлийн банк
А3ЗА	Авто замын засвар, арчлалт
АЗУАГТН	Авто замын уур амьсгалын геотехникийн нөхцөл
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНБД	Барилгын норм ба дүрэм
ЗЗБНБД	Зам, замын байгууламжийн норм ба дүрэм
ЗТХТ	Зам, тээврийн хөгжлийн төв
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ИТА	Инженер техникийн ажилтан
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХБ	Төсөл хэрэгжүүлэх байгууллага
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШУДАГ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлгээ.

Аудитын зорилт:

“Бус нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто замын шинэчлэлтийн ажлын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Төслийн хэрэгцээ, шаардлагыг оновчтой тодорхойлж, үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;*
- *Төслийн үйл ажиллагаа хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй явагдаж байгаа эсэх.*

Аудитын хамарсан хүрээ:

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолд тус аудитын сэдэв “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төслийн хэрэгжилт, үр дүн” гэсэн нэрээр тусгагдсан бөгөөд уг арга хэмжээний батлагдсан зураг, төсөлд замын нийт уртыг 204.11 км гэж тодорхойлсон тул аудитын тайланд энэ тоо хэмжээгээр авсан болно.

Аудитад ЗТХЯ, ЗТХТ, “Бус нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалт”-ын төслийн нэгж, зөвлөх, гүйцэтгэгч компаниудын 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаарх төслийн хэрэгжилттэй холбогдох үйл ажиллагаа, авто замын техник эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөл, төсөвт өртөг, барилгын ажлын болон санхүүжилтийн гүйцэтгэл, үйл ажиллагааны тайлан, мэдээ, холбогдох баримт материалуудыг хамруулав.

Авто замын барилгын ажлыг 2019 оны 6 дугаар сарын 16-ны өдөр эхлүүлсэн бөгөөд зам, замын байгууламжийн угсралтын ажил дуусаагүй, төсөлт өртөг, барилгын ажлын болон санхүүжилтийн гүйцэтгэл, үйл ажиллагааны тайлан, мэдээ, холбогдох баримт материалуудыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 300, 3000-3100, 5400-5499, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан асуудал эрхэлсэн байгууллага, холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, цахим сангаар иргэд, олон нийтээс асуулга авах, үнэлэх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур, үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.
Үүнд:

- Төслийн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- АХБ-ны худалдан авах ажиллагааны журам;
- Авто замын салбарт мөрдөгдөж буй норм, дүрэм, стандартууд;
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт;
- Дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрүүд.

Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ахлах аудитор Б.Болормаа, аудитор М.Доржмаа, Ш.Наранбаатар нар аудитын талбарын ажлыг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр эхлүүлж, 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хотоос Дарханы чиглэлд хатуу хучилттай авто зам барих ажлыг 1937 онд эхлүүлснээр эхний 108 км замыг 1943 онд ашиглалтад оруулсан бол үлдсэн хэсгийг хайрган хучилттайгаар барьж ашиглаж байсныг 1971-1972 онд хатуу хучилттай болгосноор Дархан хот нийт 204 км урт, асфальт бетон хучилт бүхий 2 эгнээ авто замаар нийслэлтэй холбогджээ.

Тус замын ашиглалтын явцад ээлжит ба урсгал засвар, арчлалтын ажлыг улсын төсвийн болон хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрийн санхүүжилтээр гүйцэтгэж ирсэн хэдий ч авто замын өнөөгийн нөхцөл байдал ашиглалтын шаардлага хангахгүй болсноор шинэчлэн сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Зам, тээврийн салбарт эдийн засгийн өсөлтийг дэмжиж, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ бүхий зам, тээврийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх гэсэн зорилтын 2.225 дахь хэсэгт “Автомозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлэх” гэж заасан байна.

Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 140 дүгээр тогтооолоор Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталж, уг хөтөлбөрт “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалт”-ын төслийг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажлыг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж 1 дүгээр шатанд хийх шинэчлэлтийн ажлыг АХБ-ны хөрөнгө оруулалтаар 2019 оны 6 дугаар сард эхлүүлсэн бол 2 дугаар шатны өргөтгөлийн ажлыг Европын сэргээн босголт банкны санхүүжилтээр 2021 онд эхлүүлэхээр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гэрээ байгуулах шатанд ажиллаж байна.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:		“Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлт, өргөтгөлийн ажил
Төслийн санхүүжүүлэгч:	1 дүгээр үе шатны шинэчлэлтийн ажил	Азийн хөгжлийн банк
	2 дугаар үе шатны өргөтгөлийн ажил	Европын сэргээн босголт банк
Төслийн нийт хөрөнгө оруулалт		Азийн хөгжлийн банкны 83.4 сая ам.долларын зээл Азийн хөгжлийн банкны өндөр технологийн сангийн 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламж Европын сэргээн босголт банкны зээлийн хөрөнгө Монгол Улсын Засгийн газрын гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төслийн дотоодын эх үүсвэрийн 6.5 тэрбум төгрөг
Төсөл хэрэгжүүлэгч:		Зам, тээврийн хөгжлийн яам
Төсөл хэрэгжүүлэх нэгж:		“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалт”-ын төсөл
Хяналтын зөвлөх үйлчилгээний компани:		БНЭҮ-ын “Интерконтинентал Консалтантс энд Технократс” компани болон туслан гүйцэтгэч Монгол Улсын “Ай Си Ти Сайн Консалтинг” ХХК
Зураг төслийн гүйцэтгэгч		“Эм Си Пи Си Жи Ар” ХХК
Төслийн гүйцэтгэгч байгууллага		“Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК “Гүйжэү хайвэй инженеринг групп”ХХК “Чайна жео инженеринг” ХХК
Гэрээ байгуулсан хугацаа		2019 оны 6 дугаар сарын 12, 6 дугаар сарын 14-ний өдөр
Төслийг ашиглалтад оруулах хугацаа		2020 оны 6 дугаар сарын 20

БҮЛЭГ 1. ТӨЛӨВЛӨЛТИЙН БОЛОН ЗУРАГ, ТӨСЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ШАТАНД ЗАРИМ ЗӨРЧИЛ ГАРСАН БАЙНА

Авто замыг өргөтгэн шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болсон нь судалгаагаар тогтоогдсон байна

1.1 “Улаанбаатар-Дархан чиглэл”-ийн олон улсын чанартай 204.11 км хатуу хучилттай зам нь Монгол Улсын авто замын сүлжээний АН-3 чиглэлийн А0401 дугаартай IV ангиллын 2 эгнээ бүхий авто зам бөгөөд Ази Европыг холбосон, ачаа тээврийг нэвтрүүлэх эдийн засгийн гол коридор буюу энэ чиглэлийн зам харилцааг хөгжүүлэх нь тус салбарын стратеги зорилтуудын нэг болж байна.

Зураг 1. Авто замын байршилын тойм зураг



Эх сурвалж: “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын зураг төслийн тайлбар бичиг

1.3 Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.4 дэх хэсэгт төрөөс үндэсний авто замын сүлжээг хөгжүүлэхэд баримтлах зарчмыг “...авто замын сүлжээг хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөгөөтэй уялдуулан, ...удирдлагын нэгдмэл бүтэц, тогтолцоотойгоор ...батлагдсан стандарт, норм нормативын дагуу, ...хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар барьж байгуулах, ашиглах...” гэж тодорхойлжээ.

1.4 Засгийн газрын 2009 оны 279 дүгээр тогтоолоор баталсан “Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 2010 онд хийгдсэн судалгаагаар “Авто замын аюултай, осол гэмтлийн онцгой бүсүүд”-ийн жагсаалт, 2011 онд Мянганы сорилтын сан, ЭМЯ, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлсэн нийслэл, орон нутгийн замуудын аюултай цэгүүдийг тодорхойлох судалгаагаар “Улаанбаатар-Дархан чиглэл”-ийн зам дагуух хэд хэдэн хэсгүүд “авто замын аюултай” цэгээр тус тус бүртгэгдсэн байна.

1.5 Мөн 2013 онд Зам, тээврийн яам /хуучин нэрээр/, Замын цагдаагийн газар /хуучин нэрээр/, БНСУ-ын Зам тээврийн аюулгүй байдлын газрууд хамтран манай улсад хэрэгжүүлсэн “Хар цэг” төслийн судалгаагаар уг замыг ослын өндөр эрсдэлтэй замд хамруулсан байна. Судалгааны ажлын дүгнэлтэд замын нөхцөл байдлаас шалтгаалсан осол, хэргийн тоог бууруулах зорилгоор авто замын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, стандартыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, замын үзүүлэлтүүдийг агуулсан Үндэсний мэдээллийн санг бий болгож, хөдөлгөөний аюулгүй байдалд тэргүүлэх ач холбогдол өгч ажиллах шаардлага байгааг дурдажээ.

1.6 Авто замын салбарын дунд, урт хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тус салбарын хууль, эрх зүйн орчин сайжирч, стандарт, дүрэм, журам шинэчлэгдсэн хэдий ч Монгол Улсын авто замын сүлжээний гол хэсгийг бүрдүүлж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг одоогийн стандартад нийцүүлэн шинэчлэх ажил хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрээс шалтгаалан удааширснаас тус замын нөхцөл байдал

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан


ашиглалтын шаардлага хангахгүй болж, улмаар шинэчлэлтийн ажлыг эхлүүлэхээс өмнө дараах байдалтай байсан байна. Тухайлбал:

- “Улаанбаатар-Дархан чиглэл”-ийн 204.11 км замын 190 гаруй км буюу 93 хувь нь хучилтын эвдрэлд орсон, далангийн 70 гаруй хувь буюу 150 км орчим нь ачаа даацын үзүүлэлт хангахааргүй болсон;
- Асфальт бетон хучилтын 3-6 метр тутамд 4 см хүртэл өргөн хэмжээтэй хөндлөн, дагуу хагарлууд ихээр үүссэн;
- Авто замыг нийтэд нь хатуу хучилттай болгосноос 24 жилийн дараа хэсэгчилсэн их засвар, шинэчлэлтийн ажил хийсэн боловч 90 орчим хувь нь дахин эвдрэлд орсон.

1.7 Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаар 2017 оны байдлаар хоногт дунджаар 5800 тээврийн хэрэгсэл өнгөрч байсан бол оргил ачааллын үед хоногт 12000 гаруй тээврийн хэрэгсэл зорчсон гэсэн үзүүлэлт гарчээ.

1.8 Тус авто замын далан, суурь, хучилтад гарсан эвдрэлийн нөлөөгөөр замаар зорчиж буй тээврийн хэрэгслийн дугуй хагарах, эд ангиуд эвдрэх, улмаар зам тээврийн осол ихээр гарах болж, ослын улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирсон хэрэг зөрчил тасралтгүй гарсаар ирсэн ба сүүлийн 3 жилд тус замд 73 хүн амь наасаа алдаж, 245 хүн гэмтэж бэртсэн судалгаа, тоо мэдээлэл байна.

График 1. УБ-Дархан чиглэлийн авто замд 2017-2020 онд гарсан зам тээврийн ослын судалгаа



1.9 Судалгаанаас үзэхэд 2019-2020 онд Улаанбаатар-Дархан чиглэлийн замд гарсан осол хэргийн тоо өнгөрсөн жилүүдийнхээс буурсан үзүүлэлттэй байгаа нь тус авто замыг өргөтгөн, шинэчлэх барилга угсралтын ажлыг эхлүүлснээр тээврийн хэрэгслийг түр замаар нэвтрүүлж байсантай холбоотой байна.

1.10 Дээрх шалтгаан, нөхцөл байдлын улмаас Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд шинэчлэлт хийх хэрэгцээ, шаардлага бий болж улмаар холбогдох төрийн байгууллагууд хамтран төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх саналыг 2016 онд Засгийн газрын хуралдаанд танилцуулсан боловч тооцоо, судалгаагүй шалтгаанаар хойшлогдсон байна.

Эх сурвалж: Тээврийн цагдаагийн албаны 2020.09.24-ний өдрийн 15-1/1879 дугаартай албан бичиг

1.11 Засгийн газрын 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 58 дугаар хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн сайд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаар дамжин өнгөрөх зорчигч, ачаа тээврийн хөдөлгөөн нэмэгдэж, уг замын нөхцөл байдал хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахгүй болсноор шинэчлэн сайжруулалт хийх шаардлагатай талаар танилцуулсан бөгөөд судалгаа, тооцоог боловсруулан баталж, шаардагдах хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгосны үндсэн дээр дахин хэлэлцүүлэхээр хойшлуулсан байна.

1.12 Тухайн үед “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км хатуу хучилттай авто зам”-ын урьдчилсан судалгаа, тооцоог боловсруулаагүй, ТЭЗҮ, инженерийн нарийвчилсан зураг төсөл батлагдаагүй байсан нь ажил хойшлогдох шалтгаан болсон байна.

Төслийг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн боловч АХБ-ны санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаар концессын зүйлийн жагсаалтаас хасжээ

1.13 УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км хатуу хучилттай авто зам”-ыг 4 эгнээ зам болгон өргөтгөн, шинэчлэх ажлыг

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

концессын “зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 166 дугаар тогтоолоор шийдвэрлэжээ.

1.14 Дээрх тогтоолд үндэслэн Үндэсний хөгжлийн газар “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто зам”-ын концесс олгох уралдаант шалгаруулалтын ажлыг эхлүүлсэн боловч Засгийн газрын “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 2018 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 65 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-аас хассан нь тухайн төслийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотой байна.

1.15 Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтыг сайжруулах техник, тусламцааны төсөл”-ийн 1.0 сая ам.долларын зээлийн гэрээг 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр байгуулж, уг зээлийн хөрөнгөөр төслийн хүрээнд гүйцэтгэх ажлын суурь судалгааг хийж, зардлын тооцоо гаргах, санхүүжилт, төлөвлөгөө, засвар арчлалтын санал боловсруулах ажлуудыг 2016-2017 онд тус тус гүйцэтгэсэн байна.

1.16 Судалгааны ажлын хүрээнд “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалт”-ын төслийг АХБ-ны 60.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэснийг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр УИХ-аас 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдөр “Санхүүжилтийн өрөнхий хөтөлбөр”-ийг баталжээ.

1.17 Хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар, АХБ хооронд “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх зам засвар, арчлалтын төсөл”-ийн тус бүр нь 60.0 сая, нийт 120.0 сая ам.долларын дүн бүхий МОН-3679, МОН-3786 дугаартай зээлийн гэрээг 2018 оны 7 дугаар сарын 23, 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд тус тус байгуулсан байна.

1.18 “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд дээрх зээлийн гэрээний дагуу санхүүжих 120.0 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар нийт 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсний нэг нь “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто зам”-ыг шинэчлэн сайжруулах ажил байна.

1.19 Зээлийн гэрээнд үндэслэн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдөр АХБ болон Сангийн яам, ЗТХЯ хооронд “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж, дээрх 120.0 сая ам.доллароос “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам”-ын шинэчлэлтийн ажилд зээлийн эх үүсвэрээр 81.9 сая, тус банкны “Өндөр технологийн сан”-гийн тусламжаар 3.0 сая, нийт 84.9 сая ам.долларыг зарцуулахаар талууд тохиролцсон боловч АХБ-аас “буцалтгүй тусламжийн 1.5 сая ам.долларыг санхүүжүүлэх боломжгүй” тухай мэдэгдсэнээр тус шинэчлэлтийн ажилд нийт 83.4 сая ам.долларыг зарцуулахаар шийдвэрлэжээ.

Төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй, захиалагч байгууллага тодорхой бус байснаас ТЭЗҮ, зураг төсөл зохиох ажлыг гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгүүлсэн байна

1.20 Авто замын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ... батална” гэж заасны дагуу тус арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийн 03/17 дугаартай “Ажлын даалгавар”-ыг ЗТХЯ-аас боловсруулж, тус яамны Төрийн нарийн бичгийн дарга 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр баталсан байна

1.21 Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Авто зам, замын байгууламжийн зураг төслийг захиалагчийн баталсан даалгаерын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ” гэж заасан бөгөөд “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км хатуу хучилттай зам”-ын ТЭЗҮ, зураг төслийг “Эм Си Пи Си Жи Ар” ХХК 2017 онд боловсруулан, ЗТХТ-ийн магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна. Тус компани зураг төслийг

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

боловсруулах төлөвлөлтийн үе шатанд ААН-үүдтэй гэрээ байгуулан холбогдох судалгааны ажлуудыг гүйцэтгүүлжээ. Үүнд:

Хүснэгт 1. Авто замын барилга, байгууламжийн үе шатны ажлыг гүйцэтгэгчийн судалгаа

№	Төслийн төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн ажил	Гүйцэтгэгч байгууллагын нэр
1	Замын трассын дагуух инженер геологийн болон материалын орд газрын судалгаа	“БИГС” ХХК
2	Байр зүйн судалгаа	“Гранд инженеринг” ХХК;
3	Цахилгааны шугамыг зөөх, хамгаалах болон замын гэрэлтүүлгийн зураг төсөл	“Бодь-Эрчим” ХХК; “Аслаан” ХХК
4	Борооны усны шугамын зураг төсөл	“Хайдро Дизайн проект” ХХК
5	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	“Эс И Си” ХХК
6	Авто замын төмөр замтай огтлолцох 7 цэгийн зураг төсөл	“Эм Си Пи Си Жи Ар” ХХК

Эх сурвалж: Зураг төслийн тайлбар бичиг

1.22 Зургийн зохиогч төслийн судалгааны ажлын хүрээнд дээрх ААН-үүдтэй гэрээ байгуулан ажиллахдаа үйл ажиллагааны зардал болох нийт 3.1 тэрбум төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, 822.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий цемент бетон хучилттай, 4 эгнээ 204 км замын анхны зураг төслийг боловсруулжээ.

1.23 Харин “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн боловсруулсан дээрх зураг төслийн захиалагч нь тодорхой бус байсан боловч ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга болон холбогдох мэргэжилтнүүд энэхүү зураг төсөлд эксперт хийж, ЗТХТ-ийн 2017 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 36/2017 дугаартай дүгнэлтээр баталгаажуулсан байна.

1.24 Салбарын сайдын зөвлөлийн 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн шуурхай хуралдаанаар тус яамны авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын зураг төсөл, судалгааны ажлыг гүйцэтгэхэд “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-д дэмжлэг үзүүлж ажиллах үүрэг чиглэл өгсний дагуу зургийн зохиогч, захиалагчийн хооронд “Зураг төсөл боловсруулах” гэрээ байгуулахгүйгээр ажил гүйцэтгүүлсэн байна. Тухайлбал:

- Үндэсний хөгжлийн газрын 2017 оны 10 дугаар сарын 01/1026 дугаартай “Мэдээлэл хүсэх тухай” албан бичгээр ЗТХЯ-д хандаж “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км авто замын концесс олгох уралдаант шалгаруулалтын бичиг баримтыг боловсруулах зорилгоор тус замын ТЭЗҮ, зураг төсөл холбогдох бусад баримт материалыг ирүүлэхийг хүссэн;
- Харин тухайн үед “Эм Си Пи Си Жи Ар” ХХК тус замын ТЭЗҮ, зураг төслийг оюуны өмчийн бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсантай холбоотой зургийн компанийд хандахыг ЗТХЯ-ны хариу бичгээр Үндэсний хөгжлийн газарт мэдэгдээжээ.

1.25 Түүнчлэн ЗТХЯ-аас 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 03/2702 дугаартай албан бичгээр Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт хандаж “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204 км зам”-ыг өргөтгэн, шинэчлэх төслийн ТЭЗҮ, зураг төслийг “Эм Си Пи Си Жи Ар” ХХК өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн талаар мэдэгдсэнээр зохиогч байгууллага зураг төслийг оюуны өмчийн бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авсан байна.

1.26 Харин тухайн үед Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, ЗТХЯ-аас мэдээлэл авахаар албан ёсоор хандсан баримт, бичиг болон зургийн зохиогчийн авсан “Оюуны өмчийн гэрчилгээ” түүнтэй холбоотой баримт материал тус яамны архивын баримтад бүртгэгдээгүй байна.

Компанийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн зураг төслийн зардлыг улсын төсвөөс төлүүлэх шийдвэр гарсан байна

1.27 “Бүс нутгийн авто замыг хөгжүүлэх засвар, арчлалтын төсөл”-ийн хүрээнд “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ыг шинэчлэх арга хэмжээг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах шийдвэр 2018 онд гарсан байна. Харин Үндэсний хөгжлийн газар

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

тухайн үед Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4¹, 28.5², 28.6³, 29.4⁴ дэх хэсэгт заасныг хэрэгжүүлээгүй, ЗТХЯ Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4⁵ дахь хэсэгт заасны дагуу төслийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулаагүй байна.

1.28 Төслийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн боловч холбогдох төрийн байгууллагууд тухайн арга хэмжээний үр өгөөжийн тооцоо судалгааг хийгээгүй, салбар хариуцсан яам авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах эрх бүхий байгууллагыг сонгон шалгаруулах замаар гэрээ байгуулж ажиллаагүй байна. Харин зураг төслийн зохиогч “Эм Си Пи Си Жи Ар” ХХК, ЗТХЯ-тай гэрээ байгуулахгүйгээр ажил гүйцэтгэсэн хэдий ч ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилтэд зарцуулсан 3.1 тэрбум төгрөгийг тус яамнаас нэхэмжилсэн байна. Үүнд:

- “Эм Си Пи Си Жи Ар” ХХК 2018 оны 01 дүэээр сарын 12-ны өдрийн 12/18 дугаартай албан бичгээр ЗТХЯ-д хандаж зураг төслийн ажлын санхүүжилтийг хүссэн бол тус яамнаас зургийн байгууллагад 2018 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн албан бичгээр Монгол Улсын 2017, 2018 оны төсвийн тухай хуульд зураг төсөл боловсруулах ажлын санхүүжилт тусгагдаагүй тухай мэдэгджээ.

1.29 Энэ нь зураг төсөл боловсруулах арга хэмжээний санхүүжилт улсын төсөвт тусгагдаагүй байхад ААН-тэй гэрээ байгуулахгүйгээр ажил гүйцэтгүүлсэнтэй холбоотой бөгөөд зургийн зохиогч “Эм Си Пи Си Жи Ар” ХХК захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж ЗТХЯ-аас 3.1 тэрбум төгрөгийг нэхэмжилснээр төлбөрийг тус яамнаас төлүүлэхээр шүүхээс шийдвэрлэжээ.

Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шийдвэгдсэнээр 2017 онд гүйцэтгэсэн ТЭЗҮ, судалгааны ажилд үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр зураг төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг 2018 онд байгуулжээ

1.29 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих арга хэмжээний жагсаалтын VIII.1.4.1-д “Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын бэлтгэл ажил, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /улсын хэмжээнд/” гэсэн арга хэмжээний хүрээнд нийт 16.0 тэрбум төгрөг батлагджээ.

1.30 Сангийн сайдын 2018 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн “Зураг төслийн ажлын жагсаалт батлах тухай” 206 дугаар тушаалаар дээрх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн жагсаалтыг баталж, холбогдох журмын дагуу санхүүжүүлэхээр шийдвэрлэснээр уг жагсаалтад “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам”-ын засвар шинэчлэлтийн зураг төсөл” гэсэн нэрээр 902.9 сая төгрөг батлагдсан байна.

1.31 Зураг төслийн санхүүжилт батлагдсанаар ЗТХЯ, АХБ-ны 83.4 сая ам.долларын хөрөнгө оруулалтад үндэслэн төслийн анхны зурагт өөрчлөлт оруулах, мөн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх ажлын зураг төслийг боловсруулах “Ажлын даалгавар”-ыг 2018, 2019 онд тус тус баталжээ.

¹ 28.4. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.1-28.3.8-д заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийн.

² 28.5. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төслийг энэ хуулийн 28.3.9, 28.3.11-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулна.

³ 28.6. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тоогоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийн.

⁴ 29.4. Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгоогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁵ 18.5.4. тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх;

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Дурслэл 1. УБ-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэх болон өргөтгөх ажлын зураг төсөл боловсруулах “Ажлын даалгавар”-үүд



Эх сурвалж: ЗТХЯ-ны ТНБД-ын баталсан “Ажлын даалгавар”-үүд

1.33 Ажлын хэсэг тус яамны Төрийн захиргаа, удирдлагын газраас өгсөн чиглэлийн дагуу “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-тай шууд гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд ингэхдээ ТБОНӨХБАУХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.1.2⁶, 34.2⁷ дахь хэсэгт заасныг тус тус үндэслэл болгосон байна.

1.34 Ийнхүү ЗТХС-ын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 03/5656 дугаартай албан бичгээр “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-д хандан гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлснээр 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн инженерийн зураг төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвлөх үйлчилгээ”-ний 222 дугаартай гэрээг байгуулжээ.

1.35 Гэрээний дагуу “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн 2017 онд боловсруулсан Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажлын зураг төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 2. Зураг төсөл боловсруулах гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын төсөв, сая төгрөг

№	Зураг төсөл боловсруулах ажлын нэр	1 дүгээр шат /шинэчлэлт/	2 дугаар шат /өргөтгөл/
1	Авто замын зураг төсөл	518.1	171.1
2	Гүүр хиймэл байгууламжийн зураг	21.1	
3	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ		70.0
4	Магадлалын дүгнэлт		37.8
5	НӨАТ 10%		78.1
6	Норм, нормативын сан 0.4%		2.5
Нийт дүн			898.4

Эх сурвалж: ЗТХЯ болон “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээ

1.36 Гэрээний нийт үнэ 898.4 сая төгрөг бөгөөд санхүүжилтийг улсын төсвөөс гаргаж, зургийн гүйцэтгэгчид бүрэн олгосон байна.

Барилга угсралтын 1 болон 2 дугаар шатанд баригдах замууд хийц, төлөөвлөлтийн үзүүлэлтүүдээрээ ялгаатай байна

1.37 “Эм Си Пи Си Жи Ар” ХХК “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ыг шинэчлэх ажлын ТЭЗҮ, судалгаанд үндэслэн 2017 онд боловсруулсан зураг төсөлдөө тус авто замын шинэчлэлтийн ажил, хиймэл байгууламж болон тунель, нүхэн гарцууд, тохижилтын ажлуудыг

⁶ “оюуны өмчийн эрх, соёлын биет өөвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол”

⁷ 34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

тусгаж, барилга угсралтын ажлын нийт төсөвт өртгийг 822.6 тэрбум төгрөгөөр тооцож 2017 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 36/2017 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байдаг.

1.38 Засгийн газар, АХБ-тай байгуулсан зээлийн гэрээ болон ЗТХЯ, “Эм Си Пи Си Жи Ар”ХХК-ийн хооронд байгуулсан “Авто замын шинэчлэлтийн инженерийн нарийвчилсан зураг төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ”-г тус тус үндэслэн ЗТХЯ-аас 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 06/810 дугаартай албан бичгээр тус компанид “авто замын шинэчлэлтийн ажлын төсөвт өртөгт магадалшгүй ажлын зардлыг оролцуулан 83.4 сая ам.долларт багтаан төсвийг шинэчлэн боловсруулж ирүүлэх”-ийг мэдэгдсэн байна.

1.39 Ингэснээр тус компани 2017 онд боловсруулж, баталгаажуулсан зураг төсөлдөө өөрчлөлт оруулж 204.11 км замыг 5 багцад хуваан барилга угсралтын ажлын зургийг шинэчлэн боловсруулж 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 15/2019 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажуулжээ. Эдгээр 5 багц ажлын төсөвт өртгийг нийт 219.6 тэрбум төгрөгөөр тооцсоныг мэргэжлийн эксперт хянаж 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 27/2019 дүгнэлтээр тус тус баталгаажуулсан байна.

Хүснэгт 3. Барилга угсралтын үе шатны ажлын зураг төсвийг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байдал,

Багц	Нэгдүгээр шатны ажлын зураг төслийг баталгаажуулсан дараалал					Хоёрдугаар шатны ажлын зураг төслийг баталгаажуулсан дараалал	
	2017.08.08-ны №36/2017		2019.02.14-ний №15/2019		2019 оны 3 сарын 21-ний №27/2019	2019.05.10-ны №49/2019	2019.09.10-ны №115/2019
Багц 1	Авто зам Туннель Нүхэн гарц Гүүр давааны ажил	төсөвт өртөг /сая төгрөг/ 157,771.0	нэгж	урт	төсөвт өртөг /сая төгрөг/	төсөвт өртөг /сая төгрөг/	
			зам	км	37.26	37,594.3	73,668.2
			гүүр	у/м	10.64	403.166	364.1
Багц 2	Авто зам Нүхэн гарц Гүүр давааны тохижилтийн ажил	283,494.2	гүүр	у/м	10.64	417.790	365.8
			зам	км	45.50	50,094.7	94,029.3
			гүүр	у/м	10.64	415.985	402.5
			гүүр	у/м	10.64	422.426	368.0
			гүүр	у/м	18.7	802.545	1,306.0
			гүүр	у/м	18.7	682.717	1,299.0
			гүүр	у/м	26.08	1,657.4	1,642.6
Багц 3	Зам, гүүр, гарц	258,586.5	зам	км	45.74	47,460.0	89,729.0
Багц 4	Зам, гүүр, туннель, нүхэн гарц	122,773.3	зам	км	45.08	44,376.8	84,307.0
			гүүр	у/м	26.08	1,618.5	1,605.6
			гүүр	у/м	101.08	-	5,260.1
Багц5			зам	км	30.53	33,724.4	60,673.4
		822,600.0			219,670.7	415,020.6	355,718.4

Эх сурвалж: ЗТХТ-ийн баталсан магадлалын ерөнхий дүгнэлт

1.40 “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто зам”-ын шинэчлэлтийн ажлын төсөвт өртгийг 2017 онд 822.6 тэрбум төгрөгөөр боловсруулж батлуулсныг 2019 онд шинэчлэн боловсруулж 219.6 тэрбум төгрөг болгож бууруулсан нь тус авто замын хучилтын хийц болон бусад төлөвлөлтийн шийдлийг өөрчилсөнтэй холбоотой байна.

1.41 Мөн Европын сэргээн босголт банкны хөрөнгө оруулалтаар тус замыг өргөтгөх 2 дугаар шатны өргөтгөлийн ажлын зураг төслийг 2019 онд боловсруулж, төсөвт өртгийг нийт 415.0 тэрбум төгрөгөөр тооцсоныг мэргэжлийн экспертууд хянаж, 2019 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 49/2019 дугаартай магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан боловч энэ зураг төсөлд дахин өөрчлөлт оруулжээ.

Хүснэгт 4. “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто зам”-ыг шинэчлэх, өргөтгөх ажлын зураг төсөл, төлөвлөлтийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал,

Авто замын төлөвлөлтийн үзүүлэлтүүд	Хэмж их нэж	Магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан зураг						
		2017.08.08-ны №36/2017	2019.02.14-ний №15/2019	2019.03.21-ний №27/2019	2019.05.10-ны №49/2019	2019.09.10-ны №115/2019		
Замын нийт урт	км	204	171.08	33.03	202.4	1.6	134.9	69.2
Далангийн өргөн	м	21.6	11	22	11	22	12	22
							12	22

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Зорчих хэсгийн өргөн	м	14	7	14	7	14	7	14	7	14
Зааглах зуварын өргөн	м	2.6	-	2.6	-	2.6	-	2.6	-	2.6
Хүчинтэй хөвөө	м	2	2	2	2	2	2	2	2	2
Хайрган хөвөө	м	3	2	3.4	2	3.4	3	3.4	2	3.4
Цемент-бетон хучилт	см	24	-	-	-	-	-	-	-	-
Өнгө асфальт-бетон хучилт	см	-	4	-	5	-	4	-	4	-
Суурь асфальт-бетон хучилт	см	-	-	6	-	-	6	-	6	-
Цементээр бэхжүүлсэн суурь	см	18	-	-	-	-	-	-	-	-
6%Це.бэхжүүлсэн суурь	см	-	-	20	-	20	-	20	-	20
3%Це.бэхжүүлсэн суурь	см	-	-	20	-	20	-	20	-	20
Суурийн доод үе	см	36	-	30	-	30	-	30	-	30

Эх сурвалж: 3THT-ийн баталсан магадлалын өрөнхий дүгнэлт

1.42 Хүснэгтээс үзэхэд 2019 оны 2 дугаар сард батлуулсан эхний зургаар хуучин ашиглаж байсан замыг нийтэд нь шинэчилж, үүнээс 33.03 км газарт даланг 22 м-ийн өргөнтэй барихаар төлөвлөж байжээ. Харин 2 дахь хувилбар буюу одоо ашиглаж байгаа зургаар Дархан хотос гарах тойрог уулзвараас 1.6 км зайд даланг 4 эгнээ 22 м өргөнтэй барьж, бусад хэсэгт хуучин 2 эгнээ замыг шинэчлэхээр төлөвлөжээ.

1.43 Мөн хучилтын хийцийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулж суурь үед 6 см, өнгөн үед 4 см нийт 10 см зузаан асфальтбетон хучилт байгуулахаар төлөвлөж байсныг зөвхөн өнгөн үед 5 см зузаантай асфальтбетон хучилт хийхээр өөрчлөлт оруулсан байна. 2019 оны 2 дугаар сард батлагдсан зураг төслийн дагуу хийгдэх барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тухайн үед тооцоогүйгээс шалтгаалж, эдгээр төлөвлөлтийн өөрчлөлтөөс гарах үнийн зөрүүг тооцох боломжгүй байна.

1.44 Харин одоо баригдаж буй замын далангийн өргөн 2 эгнээтэй хэсэгтээ 11 м өргөнтэй бол 2 дугаар шатны өргөтгөх ажлын хүрээнд баригдах замын далан 2 эгнээтэй хэсгүүдэд 12 м-ийн өргөнтэйгээр төлөвлөгдсөн бөгөөд хучилтын хийц суурь үедээ 6 см, өнгөн үед 4 см нийт 10 см зузаан асфальтбетон хучилттай байхаар төлөвлөсөн байна.

1.45 Төсөвт өртгийн хувьд pk4+107.4 дээр баригдах 101.8 у/м 1 ширхэг гүүр болон авто замыг хүчитгэх, замын дагуу хийгдэх төмөр хашлагийн ажлуудыг нийт тоо хэмжээнээс хасаж тооцсоноор эхний дүгнэлтээр батлагдсан төслийн дүнгээс 59.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 355.7 тэрбум төгрөгөөр тооцсоныг эксперт хянаж баталгаажуулсан байна.

1.46 Ийнхүү дээрх 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан зураг төслийн дагуу “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам” нь цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь бүхий 5 см зузаан асфальтбетон хучилттай, 7-14 м зорчих хэсэг бүхий 11-22 м өргөн далантай, замын турш нийт 60 уулзвар, 45 гарц, 64 шороон гарц, 13 зогсоолын талбайтай баригдахаар төлөвлөгдсөний дагуу хуучин замыг шинэчлэх 1 дүгээр шатны барилгын ажил хийгдэж байна.

1.47 Барилга угсралтын ажлын үндсэн хэсэг болох авто зам, төмөр бетон гүүр, хоолой хиймэл байгууламж барих ажлуудын зураг төсөлд нийт 5 удаагийн магадлал хийгдэж, тухай бүрт дүгнэлт гаргасан нь экспертууд “Ажлын даалгавар”, төлөвлөлтийн үеийн судалгааны ажил, газар дээрх бодит нөхцөл байдалтай зураг төслийг уялдуулах зорилгоор хяналтын шатанд зарим шийдлийг өөрчлөх, алдаа зөрчлийг запруулах, заавар зөвлөмж өгч, холбогдох санал, дүгнэлтийг гаргаж, запруулга хийж байсантай холбоотой байна.

1.48 Европын сэргээн босголт банкны хөрөнгө оруулалтаар тус замыг өргөтгөх 2 дугаар шатны ажлын хүрээнд баригдах 202.4 км авто зам нь хийц төлөвлөлтийн үзүүлэлтүүдээрээ одоо баригдаж байгаа 204.11 км замаас өргөн болоод хучилтын хувьд илүү зузаан төлөвлөгдсөн нь төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээтэй холбоотой байна.

1.49 Шинэчлэгдэн баригдаж буй 204.11 км замын хучилтын зузааныг 5 см болгож анхны төлөвлөлтийг багасгасан нь хучилт хурдан эвдрэх, засвар арчлалтын хөрөнгө ихээр шаардах, улмаар авто замын чанар байдалд сөргөөр нөлөөлж, насхилтын хугацааг багасгах эрсдэлтэй

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

тул цаашид энэ чиглэлийн 4 эгнээ замын чанар байдал, ашиглалтын түвшин, аюулгүй байдалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.50 Зохиогч нь авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулахдаа дайран өнгөрч буй төв суурин газруудын хөгжлийн төлөвлөлттэй уялдуулж, төмөр зам, эрчим хүч, цахилгаан холбоо, байгаль, орчны болон тухайн орон нутгийн түүх археологи зэрэг бүх шийдлүүдийг холбогдох байгууллагатай зөвшилцэн батлагдсан норм, дүрэм стандартыг мөрдөж ажилласан байна.

Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмаар оролцогч наарт тавигдах санхүүгийн шалгуур нь дотоодын компаниудын тендерт оролцох боломжийг хязгаарласан байна

1.51 Засгийн газар, АХБ хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрт уг зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг тус банкны ХАА-ны журмаар зохион байгуулах, мөн 5.0 сая ам.доллароос дээш өртөгтэй ажил үйлчилгээний тендерийг олон улсад нээлттэй зарлах гэсний дагуу “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын шинэчлэлтийн ажлын тендерийг журмын 2.7⁸-д зааснаар 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдөр, АХБ-ны цахим хуудас болон “Өдрийн сонин”-д нээлттэй зарласан байна.

1.52 Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хороог ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 68 дугаар тушаалаар байгуулж, бүрэлдэхүүнд тус яамны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд, хувийн хэвшлийн төлөөлөл, “Монголын авто замчдын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал, менежер зэрэг нийт 9 хүн ажиллан, АХБ-ны жишиг баримт бичигт үндэслэн журмын 2.15-д⁹ заасны дагуу тендерийн материалыг боловсруулж, урьдчилсан байдлаар 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлжээ.

1.53 Урьдчилсан байдлаар хүргүүлсэн тендерийн баримт бичигт “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажлыг дараах 5 багцад хувааж гүйцэтгүүлэхээр багц тус бүрийн ажлын тоо хэмжээ, үнэлгээний нэгж өртөг, бусад холбогдох мэдээлэл зэргийг тусгасан байна.

Хүснэгт 5. УБ-Дархан чиглэлийн 204.11 км замыг 5 багцад хуваасан хэсгүүдийн байршил

Багцууд	Замын хэсэг	Цэгийн байршил	Замын урт /км/
Багц 1	Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэл	пк0.00-пк37.26	37.26
Багц 2	Хар модот давааны араас Урьхан хүртэл	пк37.26-пк82.76	45.50
Багц 3	Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэл	пк82.76-пк128.50	45.75
Багц 4	Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэл	пк128.50-пк173.58	45.08
Багц 5	Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог хүртэлх	пк173.58-пк204.11	30.53

Эх сурвалж: Батлагдсан зураг, төсөл

1.54 Мөн түүнчлэн үнэлгээний хорооны гишүүд зам барилгын үндэсний компаниудыг сонгон шалгаруулалтад оролцуулах боломжийг бүрдүүлэх үүднээс журамд заасан ААН-ийн борлуулалтын орлогын сүүлийн 3 жилийн дундаж, түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээнд тавигдах зарим шаардлагыг бууруулах байдлаар тооцож хүргүүлсэн боловч АХБ-ны худалдан авах ажиллагааны журмаар санхүүгийн шаардлагыг тодорхой томьёоллоор тооцдог тул саналыг хүлээн авах боломжгүй гэж үзжээ. Тухайлбал,


⁸ “Олон улсын өрсөлдөөнөт тендер шалгаруулалттай төслийн хувьд, зээлдэгч нь ХАА-ны өрөнхий зарын төслийг бэлтгэн АХБ-нд хүргүүлнэ. Түүнийг хэвлэн нийтлэх ажлыг АХБ зохион байгуулна”

⁹ АХБ-ны ажлын хэл нь англи хэл байна. Тендер шалгаруулалт болон бусад холбогдох баримт бичиг, тухайлбал тендер шалгаруулалтын зарыг англи хэл дээр боловсруулна. Нэгээс дээш хэл баримталж байгаа тохиолдолд англи хэлний хувилбарыг баримтална

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

- Оролцогч компаниудын борлуулалтын орлогыг төслийг хэрэгжүүлэх хугацаанд ногдох төсөвт өртгийг 2 дахин нэмэгдүүлж.
- Түргэн хөрөвөх чадвартай хөрөнгийг төслийн төсөвт өртгийн сард ногдох хэмжээг 3 дахин өсгөснөөр тус тус тооцдог байна.

График 2. АХБ-ны ХАА-ны журамд заасан дээрх аргачлалаар ААН-үүдийн борлуулалтын орлогыг харьцуулсан узүүлэлт



1.55 Графикаас харахад багц бүрд ажиллах ААН-үүдийн борлуулалтын орлого 19.0-31.0 сая ам.доллар бол зөвхөн 1 багцын ажлыг гүйцэтгэхэд компанийн дундаж орлого 25.0 сая ам.доллар байх шаардлагатай нь манай улсын авто замын салбарт үйл ажиллагаа явуулж буй зам барилгын үндэсний компаниудын хувьд өндөр шалгуур болж байгаа учраас сонгон шалгаруулалтад оролцох боломж хязгаарлагдсан байна.

1.56 Авто замын салбарт гадаадын тэр дундаа АХБ-ны зээл, тусlamжийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд гүйцэтгэгчээр шалгаран ажилладаг жишиг бий болоод багагүй хугацаа өнгөрч байна. Энэ нь гадаадын компаниудын хүчин чадалд тулгуурлан улсын авто замын сүлжээг өсгөн нэмэгдүүлэх, улмаар салбарын хөгжилд эрэг нөлөөтэй боловч нөгөө талдаа дотоодын компаниуд томоохон төсөлд оролцож чадахгүй байгаагаас тэдний чадавхыг сайжруулах боломж алдагдаж байна. Тухайлбал,

- “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын гүйцэтгэгч шалгаруулах тендерт оролцогчдоос ирүүлэх саналыг АХБ-ны ХАА-ны журмын 2.44¹⁰-т заасны дагуу 2019 оны 5 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хүлээн авахад нийт 28 ААН санал ирүүлсэн байна.
- Тэдгээрээс 26 нь БНХАУ-ын, 2 нь дотоодын компани байсан боловч тендерийн баталгаа ирүүлээгүй, үнийн санал нь төсөвт өртгөөс давсан шалтгаанаар шалгарваагүй байна.

Хамгийн бага үнийн санал ирүүлснээр гүйцэтгэгчээр шалгарсан зарим оролцогчид гэрээг хэрэгжүүлэх чадваргүйгээс гэрээ цуцлагдсан байна

1.57 Үнэлгээний хороо зам барилгын ажлын 5 багц тус бүрд ААН-үүдээс ирүүлсэн үнийн саналыг АХБ-ны ХАА-ын журмын 2.59-д¹¹ заасныг үндэслэн 2019 оны 5 дугаар сарын 3-14-ний хооронд үнэлэх ажлыг зохион байгуулж, тайлангаа хүргүүлснийг тус банк хянан үзээд шалгарсан компаниутдтай гэрээ байгуулах зөвшөөрлийг 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр олгосноор 5 дугаар сарын 24-ний өдөр шалгарсан компаниудад мэдэгдэл хүргүүлжээ.

1.58 Авто замын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын 4 компани шалгарснаар ЗТХЯ эдгээр компаниудтай дараах байдлаар тус тус гэрээ байгуулжээ.

Хүснэгт 6. Гүйцэтгэгчээр шалгарсан компаниуд, төсөвт өртөг, гэрээний үнийн мэдээлэл

№	Гүйцэтгэгчээр шалгарсан компани	Төсөвт өртгийн дүн /сая төгрөгөөр тооцсон/		Зөрүү /сая төгрөг/	Төслийн санхүүжилт ийн дүн /ам.доллароор тооцсон/	Гэрээний дүн	Зөрүү /ам.доллар/
		Батлаадсан	Гэрээ байгуулсан				
1	“Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК	38,415.3	34,677.8	3,737.5	14,599.6	13,064.8	1,534.8
2	“Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК	54,075.8	36,570.4	17,505.4	20,551.4	13,777.8	6,773.6
3	“Гүйжэй хайвэй инженеринг групп” ХХК	47,460.0	38,464.2	8,995.8	18,037.1	14,491.3	3,545.8

¹⁰ "...6-аас доошгүй 7 хоногийн хугацааг зөвшөөрнө"

¹¹ Зээлдэгч нь гэрээ байгуулах эрхийг тендер хүчинтэй байх хугацаанд багтаан чадвар ба нөөц боломжийн хувьд холбогдох стандарт шаардлагад нийцсэн бөгөөд тендерийн баримт бичгийн шаардлагыг үндсэндээ хангасан, хамгийн бага үнийн саналтай тендерт оролцогчдод олгоно"

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км аето зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

4	“Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК	45,995.3	31,083.7	14,911.6	17,480.4	11,710.7	5,769.7
5	“Чайна жео инженеринг” ХХК	33,724.4	26,103.1	7,621.3	12,816.9	9,834.3	2,982.6
	Нийт дүн	219,670.7	166,899.2	52,771.6	83,485.3	62,879.0	20,606.5

Эх сурвалж: Батлагдсан төсөвт өртөг, гэрээ

1.59 Дээрх 5 багц ажлын гэрээний нийт дүн буюу 62.9 сая ам.долларыг гэрээ байгуулсан өдрийн буюу 2019 оны 6 дугаар сарын 12,14-ний өдрийн /2654.30 төгрөг/ дундаж ханшаар тооцсон дүн 166.9 тэрбум төгрөг бөгөөд энэ нь батлагдсан төсөвт өртгөөс 52.7 тэрбум төгрөгөөр буурсан дүн байна.

1.60 Захиалагч ЗТХЯ 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдөр зургийн зохиогчид албан бичгээр хандаж тус 204.11 км замын барилга угсралтын ажлын төсвийг магадалшгүй ажлын зардлыг оролцуулан 83.4 сая долларт багтаан гүйцэтгэж ирүүлэх чиглэл өгсөн бөгөөд энэ дүнг 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн буюу зураг, төсөв батлагдсан өдрийн Монгол банкны ханш /2631.25 төгрөг/-д хөрвүүлэн тооцоход 219.7 тэрбум төгрөг буюу хяналтын төсөвт өртгийн дүнтэй тэнцүү байна.

1.61 Харин төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зарцуулахаар төлөвлөсөн 83.4 сая ам.долларыг батлагдсан төсөвт өртгөтэй харьцуулан тооцоход гэрээний нийт үнийн дүнгээс 20.6 сая ам.долларын зөрүүтэй байна.

1.62 Үнэлгээний хороо 2 дугаар багцад оролцсон 14, 4 дүгээр багцад оролцсон 20 оролцогчоос хамгийн сайн үнэлгээтэйгээр “Чайна стэйт шинжиан констракшн” ХХК-ийг шалгаруулж тус компанийтай 13.7 сая, 11.7 сая ам.доллароор тус 2 багц ажлын гэрээг байгуулсан боловч төслийн хэрэгжилтийн явцад гэрээ цуцлагдсан байна.

1.63 Харин бусад оролцогчдоос 2 дугаар багцад ирүүлсэн хамгийн бага үнийн санал нь 15.4-19.1 сая доллар, 4 дүгээр багцад 13.1-15.1 сая ам.доллар бол үнэлгээний хороо тендерт оролцогч компаниудын гэрээг хэрэгжүүлэх чадвар, нөөц боломжийг бодитой бус үнэлсэн нь дээрх гэрээ цуцлагдсан байдлаас харагдаж байна.

Хүснэгт 7 Тендерт оролцогч компаниудаас ирүүлсэн үнийн санал, мянган ам. доллар

	Тендерт санал ирүүлсэн компаниуд	Тендерийн багцуудад ирүүлсэн үнийн санал				
		Багц 1	Багц 2	Багц 3	Багц 4	Багц 5
1	Жиансу провинсиал транспортешн инженеринг групп	26,923.7	29,938.8	38,744.5	35,968.8	30,835.7
2	Чайна жео инженеринг корперэйшн	-	-	14,475.0	13,120.4	9,834.3
3	Шанхай констракшн	14,250.0	19,220.0	17,300.0	16,730.0	12,450.0
4	Синохайдро корперэйшн лимитэд	12,261.9	16,970.3	17,302.5	14,806.1	10,284.1
5	Чайна 19 металлург корперэйшн	14,637.5	-	17,782.4	17,506.6	-
6	Пик девелопмент	-	-	-	-	13,793.4
7	Чайна рэйлаву 20 вөрэй групп	-	32,655.4	27,094.3	28,868.8	-
8	Чайна хуashi интерпресс компани лимитед	-	-	25,079.8	24,648.8	-
9	Шанши констракшн инвестмент групп	16,017.8	22,395.2	20,132.5	19,477.0	14,463.2
10	Зежан коммунекшин констракшн групп	14,790.9	19,807.5	17,908.5	17,304.6	12,182.1
11	Гүйжуу хайвэй инженеринг групп	-	-	14,491.3	-	-
12	Шинжиан вайшн роуд бриж групп	-	-	21,359.6	17,845.8	12,239.7
13	Лонжин роуд энд бриж	14,308.1	18,245.2	16,563.8	16,403.9	12,034.5
14	Чайна нонтероус метал чаустра форенж инженеринг констракшн	52,652.6	69,110.8	-	-	-
15	Ордос лу тай хайвэй инженеринг	-	-	-	-	15,409.7
16	Чайна секонд металлург групп	14,578.3	17,670.2	17,707.4	17,649.1	11,889.8
17	Чайна тисику сивил инженеринг групп	13,380.5	-	-	16,537.7	15,970.2
18	Жиансу жиалон инженеринг констракшн	-	-	-	16,951.0	-
19	Хейпонжиан женэй роуд энд бридж	13,064.7	17,547.0	15,128.2	15,150.6	10,649.6
20	Зонмей инженеринг групп лимитед	13,953.3	15,452.3	14,481.6	13,675.5	10,608.9
21	Чайна рэйлаву интернашил групп	-	20,207.5	-	-	-
22	Чайна роуд бриж корперэйшн	-	-	-	20,052.3	14,928.9
23	Чайна гүйжоу групп компани	-	-	22,157.6	22,123.0	-
24	Чайна стэйт Шинжиан констракшн	-	13,777.6	-	11,710.7	-
25	Дажинг ойлфелд хайвэй бриж	14,370.0	19,150.4	17,100.0	16,164.7	12,160.0
26	Дерепол констракшн	-	-	17,871.1	-	-
27	Жиансу жинхэ юбо констракшн инженеринг	-	-	-	110,189.9 RNB	-
28	Шагайн жим	-	-	-	-	-

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

1.64 Энэ нь АХБ-ны ХАА-ны журмын 2.46 дахь хэсэгт заасан “тендерийн үнэлгээний зорилго нь хамгийн бага үнийн санал ирүүлснийг нь зайлшгүй сонгах бус, тус журмын 2.58 дахь хэсэгт заасан хамгийн сайн үнэлэгдсэн саналтай оролцогчийн гэрээг үр ашигтай хэрэгжүүлэх чадвар, нөөц боломжтой эсэхийг зээлдэгч магадлан тогтооно” гэсэнтэй нийцээгүй бөгөөд зөвхөн хамгийн бага үнийн саналтай оролцогчийг сонгосон нь гэрээний үнийг батлагдсан төсөвт өргөөс бууруулах эрсдэлийг бий болгосон байна.

1.65 Мөн төслийн хөрөнгө оруулалтын нийт 83.4 сая ам.долларын санхүүжилтээр авто замын барилга угсралтын үндсэн ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөж, зураг төслийг боловсруулж, төсөвт өргийг тооцсон ч гэрээ байгуулах шатанд энэ дүнг 62.9 сая ам.доллар болгож бууруулсан ба дүнгийн зөрүү 20.6 сая ам.долларыг хэрхэн зарцуулах нь тодорхойгүй байна.

1.66 Иймд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км замын шинэчлэлтийн ажилд зарцуулахаар төлөвлөсөн 83.4 сая ам.долларын зарцуулаагүй санхүүжилт 20.6 сая ам.доллар, үүнээс буцалтгүй тусламжийн 1.5 сая ам.долларыг тус замын барилгын ажлын чанарыг сайжруулахад зарцуулах, энэ ажлын судалгаа тооцоо, төлөвлөлтийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх, зарцуулалтыг тайлагнах шаардлагатай байна.

Зам барилгын ажилд хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна

1.67 Засгийн газар, АХБ хооронд байгуулсан зээлийн гэрээ, тус банкны ХАА-ны журмын дагуу “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалт”-ын төслийн зам барилгын ажилд өдөр тутмын хяналт тавих, зөвлөх үйлчилгээний компанийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 126 дугаар тушаалаар байгуулж, сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулсан байна. Тухайлбал,

- 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн өдөр тутмын сонин болон АХБ, ЗТХЯ-ны цахим сайтад тендерийн зарыг нийтэлснээр 23 компани оролцох саналаа илэрхийлсэн.
- Үнэлгээний хороо дээрх 23 ААН-ээс 6 компанийн бодино дарааллыг үүсгэж, үнэлгээний тайланг 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр АХБ-д хүргүүлсэн бөгөөд тус банкнаас зөвшөөрөл олгосны үндсэн дээр 6 компанийд урилга хүргүүлжээ.

1.68 Үнэлгээний хороо сонгон шалгаруулалтад оролцсон компаниудтай тендерийн баримт бичигт заасны дагуу тендерийн өмнөх уулзалтыг 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж 3 компани оролцсон байна.

1.69 Эдгээр компаниудаас тендерт ирүүлсэн саналыг 2017 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр нээж, саналыг хянаснаар “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажилд хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагаар БНЭҮ-ын “Интерконтинентал Консалтантс энд Технократс” компани, туслан гүйцэтгэгчээр Монгол Улсын “Ай Си Ти Сайн Консалтинг” компани тус тус шалгарч, 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдөр 4.3 сая ам.долларын үнийн дүнтэй гэрээ байгуулсан байна.

БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ СУЛ, ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ХУГАЦААГ БОДИТОЙ ТОГТООГООГҮЙ, ГЭРЭЭ ЦУЦЛАГДСАН, ХУГАЦАА ДУУССАН, АЖЛЫН ЯВЦ УДААШИРСАН БАЙДАЛТАЙ БАЙНА

Төслийн удирдах хороо үйл ажиллагаа явуулаагүй, төслийн нэгжийн удирдлага зохион байгуулалт хангалтгүй, хүний нөөц дутуугаас зарим төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлээгүй байна.

2.1 “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалт”-ын төслийн үйл ажиллагаа Монгол Улсын Засгийн газар АХБ-тай байгуулсан зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд явагдаж байгаа тул Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”- аар зохицуулагдахаас гадна холбогдох хууль, эрх зүйн актуудыг дагаж мөрдөхөөр байна.

2.2 Зээлийн гэрээ байгуулагдсанаар төслийн үйл ажиллагаа эхэлж, хэрэгжүүлэгч байгууллагаар ЗТХЯ, төслийн захирлаар тус яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга ажиллаж, журмын дагуу холбогдох чиг үүргүүдийг гүйцэтгэхээр байна.

2.3 Төслийн барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдсанаас хойш буюу 2019-2020 онд тус яамны авто замын бодлогын хэрэгжилтийг хариуцсан газрын дарга чөлөөлөгдсөн шалтгаанаар төслийн захирал 2-3 удаа солигдож, “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 4.1.7¹²-д заасан чиг үүргийн биелэлтийг хангаж ажиллаагүй байна.

2.4 Харин тус журмын 15.6¹³ дахь хэсэгт заасны дагуу ЗТХС-ын 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 56 дугаартай тушаалаар Сангийн яам, ЗТХЯ, ТХН болон холбогдох бусад байгууллагын албан тушаалтнуудын төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр төслийн удирдах хороог байгуулжээ. ТУХ нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Төслийн удирдах хорооны даргаар ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга;
- Төслийн удирдах хорооны нарийн бичгийн даргаар ТХН-ийн захирал;
- Гишүүдээр ЗТХЯ-ны авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, ХШУДАГ-ын газрын дарга, БОАЖЯ, ХНХЯ-ны холбогдох газар, нэгжийн албан тушаалтан нарын бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

2.5 Удирдах хороо нь төслийн нэгж болон захирлын хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд бодлого, удирдамжаар хангах, хяналт тавих, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор хорооны хурлыг журамд заасан хугацаанд зохион байгуулж, гарсан шийдвэрт үндэслэн ажил үүргээ гүйцэтгэх ёстой боловч байгуулагдсанаас хойш хуралдаагүй, төслийн нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийг хэлэлцэн баталсан гэх боловч тэмдэглэл, холбогдох бусад баримтаар нотлогдохгүй байна.

2.6 Удирдах хорооны үйл ажиллагаа явагдахгүй байгаа нь төслийн захирал, нэгжийн үйл ажиллагаа оновчтой бодлого, удирдамжаар зохицуулагдахгүй, ажлын төлөвлөгөө, биелэлт хангагдахгүй, улмаар төслийн зорилго, зорилтыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлэх боломжийг бууруулах эрсдэлийг бий болгож байна. Энэ нь тус хорооны үйл ажиллагааг удирдан ажиллаж буй төсөл хэрэгжүүлэгч байгууллагын холбогдох албан тушаалтны чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

¹² 4.1.7.“төслийн захирал” гэж төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ТЕЗ-ийн нэрийн өмнөөс тухайн төслийг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлاغнах, төслийн явцын гүйцэтгэл, үр дүнг хариуцах, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд өрөнхий хяналт тавих, Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын тухайн төслийн хэрэгжилтийг хариуцсан нэгжийн удирдах албан тушаалтныг;

¹³ 4.1.6.“төслийн удирдах хороо” (цаашид “ТУХ” гэх) гэж төсөл хэрэгжүүлэх нэгж, төслийн захирлыг энэхүү журмын 12.1-д заасан чиг үүргийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны удирдамжаар хангах, төслийн хэрэгжилтийг хянах, салбарын болон салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус нэгжийг;

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан


2.7 Иймд төслийн удирдах хорооны даргаар ажиллаж буй ЗТХЯ-ны холбогдох албан тушаалтан чиг үүргээ хэрэгжүүлж, төслийн явцыг удирдан чиглүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, ажлын тайланг хэлэлцэн дүгнэх, шаардлагатай арга хэмжээний талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллага, төслийн нэгжид зөвлөмж хүргүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.8 Мөн Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан журмын 12.1.1-12.1.6¹⁴-д заасан ТХН-ийн захирылын чиг үүргийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын Төсвийн ерөнхийлөн захирагчийг төлөөлсөн албан тушаалтан хариуцан хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийн дагуу төслийн хэрэгжилтийн шатанд удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, гүйцэтгэл, тайлагнал үр дүнг хариуцан ажиллах шаардлагатай байна.

2.9 Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3¹⁵ дахь хэсэг, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 9.1.6¹⁶-д заасныг тус тус үндэслэн Сангийн яамнаас “Бус нутгийн авто замыг хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийг хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог баталжээ.

2.10 Сангийн сайдын “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 197 дугаар тушаалаар “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км хатуу хучилттай авто зам”-ын төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцийг нийт 9 хүний орон тоотойгоор дараах байдлаар баталжээ.

Дурслэл 2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц



Эх сурвалж: Сангийн сайдын 2018 оны 197 дугаар тушаал

2.11 Үүнээс 3 хүний орон тоогоор дутуу ажиллаж ирсэн нь сул ажлын байранд зарласан мэргэжилтний сонгон шалгаруулалтад шаардлага хангасан иргэн оролцоогүйгээс шалтгаалжээ. Хүний нөөц дутагдалтай шалтгаанаар төслийн хүрээнд хэрэгжүүлэх нийгмийн

14 12.1.1.төслийн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төсвийн шууд захирагчтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний биелэлтэд хяналт тавих;

12.1.2.төслийн хүрээнд зохион байгуулаадаа арга хэмжээний төлөвлөгөө (үүнд: сургалт, семинар, гадаад, дотоод томилолт), удирдамж, чиглэлийг тухай бүр батлах;

12.1.3.гэрээ, хэлэлцээр, батлагдсан төсөө, төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулах;

12.1.4.төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавих, төслийн үр дүнг хариуцах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ТХН-ийг удирдан зохион байгуулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар ТУХ-д тайлagnah;

12.1.5.төсөл хэрэгжүүлэгч байгууллагыг төлөөлөн төслийн санхүүгийн зарцуулалтад хяналт тавих, санхүүжилтийг хянан баталгаажуулах;

12.1.6.төслийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний хэрэгжилтийг хянах, дүгнэх, гэрээг сунгах, цуцлах болон тухайн ажилтныг урамшуулах, хариуцлага тооцох талаар санал боловсруулах, асуудлыг ТУХ, Сангийн яаманд танилцуулах.

15 11.1.3.төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тоогоох;

16 “төсөл хэрэгжүүлэгч байгууллагын саналд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч нэгжийн бүтэц, орон тоо, цалинг батлах”

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

хамгаалал болон байгаль орчны чиглэлээр хийж гүйцэтгэх төлөвлөгөөт ажлууд бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна. Тухайлбал;

Хүснэгт 8. ТХН-ийн нийгмийн болон байгаль орчны хамгааллын чиглэлээр гүйцэтгэх ажлын 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг

№	Төлөвлөгөөт ажил	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Төсвийн жил		2019 оны I,II,III,IV улирал	
2	Байгаль орчин хамгаалал	7.4	1.3	6.1
3	Нийгмийн хамгаалал	54.3	7.7	46.6
	Нийт дүн	61.7	9.0	52.7


Эх сурвалж: ТХН-ийн 2019-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гүйцэтгэл

2.12 Төслийн нэгжийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайландаа тусгаснаар 2019 оны I-IV улиралд байгаль орчны болон нийгмийн хамгааллын ажлын зардалд нийт 61.4 сая төгрөгийг тусгаж батлуулснаас 52.7 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байна.

2.13 Мөн ТХБ-аас тус нэгжийн санхүүгийн болон ХАА хариуцсан ажилтныг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Сангийн яаманд хүргүүлэх үүрэгтэй боловч сүүлийн 14 сарын хугацаанд ХАА хариуцсан ажилтныг томилоогүйгээс төслийн ХАА-ны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийн мэдээ, тайланг бэлтгэн боловсруулах ажлыг Монгол Улсын хууль тогтоомж, гэрээ, хэлэлцээрт заасны дагуу гүйцэтгэх ажилтан алга байна.

2.14 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1¹⁷ дэх хэсэг, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан журам, 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 18 дугаар тушаалыг үндэслэн тус нэгжийн бүтэц орон тоог дахин шинэчлэх саналыг боловсруулж, 2020 оны 1 дүгээр сард батлуулжээ.

Дурслэл 3. ТХН-ийн шинэчлэн баталсан бүтэц



2.15 Бүтэц орон тоог шинэчлэн батлаадаа АХБ-тай байгуулсан зээлийн гэрээний шаардлагыг зөрчиж, нийгмийн хамгаалал, байгаль орчин зэрэг хоорондын хамааралгүй чиг үүргийн ажлуудыг нэгтгэн нэг хүнээр гүйцэтгүүлэхээр бүтцийг батлуулжээ.

Эх сурвалж: Сангийн сайдын 2020 оны 18 дугаар тушаал

2.16 Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан журмын 12.1.3¹⁸, 12.1.4¹⁹-т тус тус заасны дагуу ЗТХЯ зээлийн гэрээнд тусгагдсан арга хэмжээг батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу гүйцэтгүүлэх, хяналт тавих, ТХН-ийг удирдан зохион байгуулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар ТҮХ-д тайлагнах ажлын хэрэгжилт хангагдахгүй байна.

2.17 Иймд төслийн хэрэгжилтийн шатанд хяналт, үнэлгээ хийж, гарсан дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээ авч ажиллах, ТХН-ийн үйл ажиллагааны санхүү, бүртгэлийг

¹⁷ 17.1.Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна.

¹⁸ “гэрээ, хэлэлцээр, батлаадсан төсөв төлөвлөгөөний дагуу төслийн хэрэгжилтийг хангуулах”,

¹⁹ 12.1.4.төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд өдөр тутмын хяналт тавих, төслийн үр дүнг хариуцах, хяналт-шинжилгээ, үнэлгээгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ТХН-ийг удирдан зохион байгуулах, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар ТҮХ-д тайлагнах”

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

стандартын дагуу бүртгэх, тайлагнах, ХАА-ны төлөвлөгөө, гүйцэтгэлийг ил тод мэдээлэх, ТХБ, төслийн захирал эдгээр үйл ажиллагааг удирдан зохицуулах шаардлагатай байна.

Зам барилгын үндсэн ажлыг богино хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж, гэрээ байгуулснаас чанаргүй ажил гүйцэтгэсэн байна

2.18 “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга, угсралтын ажлыг дараах 5 багцад хувааж БНХАУ-ын 4 компанийтай гэрээ байгуулсан ба захиалагч, гүйцэтгэгч талууд 2019 оны 6 дугаар сарын 21-ний өдөр улаан шугам хүлээнлцсэнээр төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлжээ.

Зураг 2. Авто замын барилга угсралтын ажлыг гүйцэтгэх 5 багцын байршил



Эх сурвалж: Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км замын зураг төслийн тайлбар бичиг

2.19 Дээрх 5 багцын барилгын ажлын нийт гүйцэтгэл 2020 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 48.1 хувь бол захиалагч, зөвлөхийн баталгаажуулснаар гүйцэтгэгч компаниудад урьдчилгаа төлбөрт олгосон 8.8 сая ам.долларыг оролцуулан гэрээний үнийн дүнгийн 46.6 хувь буюу 29.3 сая ам.долларыг тус тус олгожээ.

Хүснэгт 9. Барилга угсралтын ажлын болон санхүүжилтийн гүйцэтгэл, мянган ам.доллар

Замын хэсэг	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дүн	Урьдчилгаа санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	
					Олгосон санхүүжилт	БУА-ын
Багц 1	Хейлонжиан женэйроуд энд бридж ХХК	13,064.7	-	7,919.3	60.6	85.43
Багц 2	Чайна стэйт Шинжиан констракшн ХХК	13,777.7	2,755.5	3,946.5	28.6	9.49
Багц 3	Гүйжэу хайвэй инженеринг групп ХХК	14,491.3	2,898.2	9,083.8	62.6	69.76
Багц 4	Чайна стэйт Шинжиан констракшн ХХК	11,710.7	2,342.1	2,907.1	24.8	5.30
Багц 5	Чайна жео инженеринг ХХК	9,834.3	870.1	5,502.0	55.9	70.46
Нийт дүн		62,878.9	8,866.0	29,358.9	46.6	48.1

Эх сурвалж: ЗТХЯ-аас гаргасан судалгаа

2.20 Мөн 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар АХБ-д хянуулахаар хүргүүлсэн 1,3 дугаар багцын 2.1 сая ам.долларын гүйцэтгэл баталгаажсанаар санхүүжилт 31.5 сая ам.доллар буюу 51.0 хувьд хүрэхээр байна.

2.21 Гэрээний хугацаа 2020 оны 6 дугаар сарын 20-ны өдөр дуусгавар болсныг гүйцэтгэгч нараас ирүүлсэн хүснэгтэд үндэслэн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан ба энэ хугацаа 2020 оны 4 дүгээр улиралд дуусаж байгаа боловч нийт 204.11 км замын барилга угсралтын ажил багц тус бүрээр 5.3-85.4 хувийн гүйцэтгэлтэй буюу харилцан адилгүй байгаа нь гүйцэтгэгч компаниуд төслийн бэлтгэл болон хэрэгжилтийн шатанд гэрээ, график төлөвлөгөөг мөрджэх ажиллаагүйтэй холбоотой байна.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2.22 Замын 1 дүгээр багцын гүйцэтгэгч “Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК 2019-2020 онд нийт ажлын 85.4 хувийг гүйцэтгэсэн нь туслан гүйцэтгэгчээр Монгол компаниудыг сонгож гэрээ байгуулан ажилласантай холбоотой байна. Энэ нь гэрээний дагуу манай улсын үндэсний компаниудыг дэмжсэн, хил гаалиар ажиллах хүч, тоног төхөөрөмжийг оруулах, зөвшөөрөл авах гэх мэт асуудлууд дээр цаг хугацаа хэмнэсэн ч гэрээний заалт зөрчигдсэн байна.

2.23 Гэрээний ерөнхий нөхцөлийн 4.4-т “Гүйцэтгэгч нь ажлыг бүхэлд нь туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ёсгүй” туслан гүйцэтгэгчийн аливаа буруутай үйлдэл, алдааны хариуцлагыг ерөнхий гүйцэтгэгч өөрийн гаргасан алдаа мэт хүлээнэ гэжээ. Харин “Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК гэрээний энэ нөхцөлийг зөрчиж өөрийн хариуцсан 37.26 км замыг дараах компаниудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлснээр тус компани барилга угсралтын үндсэн ажилд оролцоогүй байна. Үүнд:

- “ЭСТО” ХХК пк0+00-пк17+060 хүртэлх нийт 17.06 км авто зам;
- “Үйлсийн зам”, “Болор Болд зам” пк17+060-пк37+260 хүртэлх нийт 20.2 км авто зам;
- “Дойч-рөүд” ХХК гүүр, хоолойн ажлыг гүйцэтгэсэн бөгөөд эдгээр компаниудын гүйцэтгэсэн ажилд чанарын шаардлага хангагүй зөрчил дутагдлууд илэрсэн байна.

2.24 Аудитын талбарын үе шатанд аудитын баг захиалагч, зөвлөх, гүйцэтгэгч байгууллагуудын төлөөлөлтэй хамтран барилга угсралтын ажилтай танилцахад 1 дүгээр хэсгийн 32.76 км замд дэвссэн асфальтбетон хучилтын тэгш байдал алдагдаж, хөндлөн дагуу хагарлууд, зарим хэсэгт нүх гарч, хучилтын залгаас хэсгүүдийн заадас ил гарсан байна.

Зураг 3. Багц 1-ийн 37.26 км замын асфальтбетон хучилтад гарсан хагарал



2.25 Хучилтад хагарал үүссэн шалтгаан, тоо хэмжээг тодорхойлох зорилгоор төслийн нэгжээс тайлбар, тодруулга авч, зөвлөх багийн ИТА-ын газар дээр нь хийсэн хэмжилтийн дүнгээр 1 дүгээр багцын 37.26 км замд хийсэн асфальт-бетон хучилтын ажлаас 6079.8 метр замыг техникийн шаардлага хангагүй, чанаргүй хийсэн байна гэж дүгнэлээ. Үүнд:

- пк0+020-пк4+556 хооронд 4,536 м газарт 1386 м,
- пк17+140-пк18+020 хооронд 850 м газарт 483.3 м,
- пк19+00-пк24+93 хооронд 5930 м газарт 4210.5 м нийт 6079.8 м газарт замын зорчих хэсгийн тэнхлэг болон баруун, зүүн хэсэгт хөндлөн, дагуу, төрон хагарлууд, жижиг нүх үүссэн байна.

Эх сурвалж: Зөвлөх багийн хэмжилтийн ажлын тайлан

2.26 Гэрээний 3 дугаар хэсгийн 3.3-т “Инженер нь гэрээний дагуу ажил гүйцэтгэхэд /голлогдлыг засах/ шаардлагатай ажлын зураг, аливаа нэмэлт зөвлөмж зааварчилгааг гүйцэтгэгчид гаргаж өгнө” гэсний дагуу захиалагчаас шаардлага хангагүй ажлуудын зураг, тоо хэмжээг гаргаагүй, засварлах ажлын заавар чиглэл өгч, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах үүрэгтэй боловч эдгээр ажлын график төлөвлөгөө, гарах зардалтай холбоотой судалгаа тооцоог гаргаагүй байна.

2.27 Аудитын явцад цуглувулсан нотлох баримтаас харахад зам барилгын ажлын үе шатанд технологийн горим зөрчигдсөнөөс шаардлага хангагүй ажлууд хийгдсэн нь зөвхөн гүйцэтгэгчээс шалтгаалаагүй, харин барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний дагуу хучилтын ажлыг 6 сарын хугацаанд дуусгахаар ажлыг шахаж, цаг урсын тохиромжгүй нөхцөл, хүйтэн сэргүүний улиралд захиалагчаас гүйцэтгэгч нарт үүрэг, чиглэл өгч ажил гүйцэтгүүлсэнтэй холбоотой байна.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2.28 Тендерийн баримт бичигт авто замын газар шорооны болон хиймэл байгууламж, хучилтын ажлуудыг багц тус бүр 12 сарын хугацаанд гүйцэтгэхээр тусгасан боловч үнэлгээний хорооноос эдгээр ажлыг 6 сарын хугацаанд гүйцэтгүүлэх тухай саналыг АХБ-д хүргүүлж, тус банкнаас ирүүлсэн хариуд 6 сарын хугацааг богино гэж үзэж байгаагаа илэрхийлсэн тул үнэлгээний хорооноос дахин 2 сарын хугацаагаар нэмэгдүүлэх санал хүргүүлсэн байна.

2.29 Харин захиалагч ЗТХЯ, Засгийн газраас үүрэг чиглэл өгсөн шалтгаанаар 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хучилтын ажлыг дуусгаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээхээр төлөвлөж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа АХБ, үнэлгээний хорооны санал, дүгнэлт, цаашлаад авто замын суурь, хучилт зэрэг улирлын чанартай гүйцэтгэх үе шатны ажлын онцлогийг харгалзан үзэхгүйгээр зам барилгын үндсэн ажлуудыг 6 сарын хугацаанд гүйцэтгүүлэхээр төлөвлөж гэрээ байгуулсан байна.

2.30 Иймд захиалагч ЗТХЯ-д барилга угсралтын ажлын 1 дүгээр багцын 37.26 км замд хийгдсэн асфальт-бетон хучилтын ажлаас техникийн шаардлага хангагүйгээс хөндлөн, дагуу хагарал, ан цав, нүх үүссэн чанарын гологдолтой 6.08 км замын асфальт-бетон хучилтын ажлыг шаардлагад нийцүүлэн дахин засварлах ажлыг зохион байгуулах хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн болно.

2.31 “Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК тендерийн шалгууруудыг хангаснаар, захиалагч тус компанийтай гэрээ байгуулсан ч барилга угсралтын ажлын бэлтгэл болон хэрэгжүүлэх үе шатанд шалгуур, нөхцөлүүдээ хангаж ажиллаагүй, хариуцсан ажлаа бие даан гүйцэтгээгүйгээс ажлын явцад дараах зөрчил дутагдууд гарчээ. Тухайлбал;

- Хяналтын инженерүүд гүйцэтгэгчийн өдөр тутмын ажилд заавар зөвлөмж, удирдамж, чиглэл өгч ажилладаг ч үе шатны ажлуудад техникийн шаардлага зөрчигдэж байсан нь тухай компанийн ИТА нарын ажлын чадвар, дадлага, туршилагатай холбоотой гэж дүгнэсэн;
- Мөн захиалагч байгууллагаас “Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК болон бусад гүйцэтгэгч компаниудад хүн хүч, тоног төхөөрөмжөө нэмэгдүүлэх, ажлыг хоцрогдлыг арилгах чиглэлээр удаа дараа шаардлага хүргүүлж байсан ч гүйцэтгэгч нар тухайн үед холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүйгээс ажлын явцыг удаашруулсан байна.

2.32 Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээлийн хөрөнгийн үр ашгийг бууруулах эрсдэлээс сэргийлж, чанаргүй ажил гүйцэтгэж улсын төсөвт хохирол учруулахгүй байх үүднээс тус авто замын барилгын ажлын чанарт илүүтэй анхаарч, техникийн шаардлага хангагүй хийгдсэн хучилт, гүүр, хоолойн ажлуудыг шаардлагад нийцүүлэн засварлах ажлыг даруй зохион байгуулах шаардлагатай байна.

2.33 Мөн одоо хэрэгжиж буй төслийн хүрээнд шинэчлэгдэн баригдаж буй 204.11 км замын асфальтбетон хучилтын үеийн зузааныг 10 см-т хүргэж нэмэгдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, авто замыг ашиглалтад оруулахын өмнө хөрөнгө санхүүжилтийг шийдвэрлэн, ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авах шаардлагатай байна.

2 болон 4 дүгээр багцын 90.5 км зам барих ажлын гэрээ цуцлагдсан байна

2.34 “Чайна стэйт Шинжиан констракшн ХХК”-ийн хариуцсан 2 дугаар багцын 45.50 км, 4 дүгээр багцын 45.08 км нийт 90.5 км замын барилга угсралтын ажил 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5.3-9.4 хувийн гүйцэтгэлтэйгээр зогссон нь тус компани гэрээний үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй, улмаар ажил гүйцэтгэх гэрээгээ цуцлах хүсэлт гаргасантай холбоотой байна. Үүнд:

- Тус компани 2019 оны барилгын ажлын улиралд 2 дугаар багын 45.05 км замын далангийн дүүргэлтийн ажлын 48.5 хувийг гүйцэтгэж, нийт 14 км-т хуучин асфальт-бетон хучилтыг хуулах ажлыг гүйцэтгэсэн бол 31.5 км замд газар шорооны ажил хийгдэж эхлээгүй байна.
- Мөн 4 дүгээр багцын 45.08 км замын далангийн дүүргэлтийн ажлын 23.02 хувийг гүйцэтгэсэн бол цементээр бэхжүүлсэн суурь хийх, асфальтбетон хучилтыг хуулах ажил хийгдээгүй байна.
- Түүнчлэн 204.11 км замын туршид нийт 258 ширхэг ус зайлцуулах хоолой, 8 гүүр барьж байгуулахаас 110 цэгийн хоолой, 6 цэгийн гүүрийн ажлыг “Чайна стэйт Шинжиан констракшн ХХК” гүйцэтгэхээр гэрээ

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

байгуулсан боловч 66 ширхэг хоолойн ажлаас бусад хиймэл байгууламжийн ажил хийгдээгүй байдалтайгаар ажил зогссон байна.

2.35 “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК 204.11 км замын барилга угсралтын нийт ажлын 44.3 хувийг гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний ерөнхий нөхцөлийн 4.1-т заасан зам барилгын түр болон байнгын ажилд шаардлагатай ажиллах хүч, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, талбайн ажлын зохион байгуулалтыг хангаж ажиллаагүй, ТХБ, ТХН болон зөвлөх компанийн ИТА нартай хамтран ажиллаагүй, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлээгүй, 2019 оны жилийн эцэст барилга угсралтын ажлаа тайлагнаж гэрээ дүгнүүлэх ажилд оролцоогүй байна. Тухайлбал,

- Гэрээний ерөнхий нөхцөлийн 4.6-д заасны дагуу тайлан мэдээгээ тухай бүрд нь гаргаж, төслийн нээж, захиалаач, зөвлөх байгууллаагүйд танилцуулаагүй,
- Барилга угсралтын ажил удааширч буй шалтгаан нөхцөлийг дурдсан баримт, тайлбар зэргийг ирүүлж холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх, барилгын ажлыг эрчимжүүлэх тал дээр шаардлагатай арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Захиалаач гэрээнд заасан үргэйн дагуу гүйцэтгэгчид хариуцлага тооцох, байгуулсан үзэрэг цуцлах хүртэлх арга хэмжээ авах хүсэлтийг АХБ-д 2019 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 03/126, 9 дүгээр сарын 27-ны өдрийн 03/157 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.
- АХБ-аас тус албан бичгийн хариуг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлэхдээ үзэрэг цуцлахад зарим эрсдэл үүсэж болзошгүйг дурдсан байна. (үзэрэг цуцлагдвал дахин тендер зарлаж хугацаа алдах, үзэрээний үнэ өсөх гэх мэт)

2.36 АХБ-ны төлөөлөл 2019 оны 11 дүгээр сарын 12-15-ны өдрүүдэд манай улсад ирж төслийн явцтай танилцаад тус компанийн хариуцсан 2,4 дүгээр хэсэгт ажиллах хүч, техник тоног төхөөрөмж байхгүй, ажлаа гүйцэтгэж чадахгүй байгаа зэрэг асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр ЗТХЯ-ны 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/198 дугаар албан бичгээр тус хоёр багцын гэрээг цуцлах тухай хүсэлтийг тус яамнаас АХБ-д дахин хүргүүлсэн боловч тухайн онд гэрээ цуцлагдаагүй байна.

2.37 “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК-ийн ажил 2019 онд график төлөвлөгөөний дагуу явагдаагүй, 2020 онд үргэлжлэн хэрэгжээгүй зогссон нь тус компанийн үйл ажиллагааны зохион байгуулалтаас шалтгаалсан боловч 2 дугаар багцын нийт ажлыг 1 дүгээр багцын ажилтай харьцуулахад тоо хэмжээний хувьд зөрүү ихтэй боловч гэрээний үнийн дүн 13.0-13.7 сая ам.доллар байна.

2.38 Гэрээний 3.5 дахь хэсэгт “захиалаагчийн инженер нь ямар нэг асуудлыг шийдвэрлэж, зөвшилцэлд хүрэх зорилгоор талуудтай зөвлөнө” гэсний үндсэн дээр 12.2 дахь хэсэгт “байнга гүйцэтгэж буй ажлын төрөл тус бүрээр цэвэр бодит тоо хэмжээг нягтлан шалгаж хэмжих”, “хэмжилт хийхдээ ажлын тоо хэмжээ болон бусад холбогдох графикийг үндэслэл болгож” зөвшөөрөгдсөн хэмжилтийн дүнг үндэслэн гүйцэтгэж буй ажлын төрөл тус бүрээр үнэлгээ хийж гэрээний үнийг тодорхойлж зөвшөөрнө гэжээ.

2.39 Хоёрдугаар багцын хувьд 8.2 км авто зам, 3,142.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 18.7-26.08 у/м 3 ширхэг төмөр бетон үүр, 16 цэгийн хоолойны ажлын тоо хэмжээгээр 1 дүгээр багцаас илүү төлөвлөгдсөн ч тус компани тендерт үнийн санал ирүүлэхдээ тендерийн бичиг баримтад тусгагдсан, талбайд хийгдэх бодит ажлын тоо хэмжээ, тухайн үеийн үнэ тарифыг бодитоор тооцоогүй байна. Энэ нөхцөл байдал 4 дүгээр багцын 45.08 км замын барилга угсралтын ажлын төлөвлөлт, тоо хэмжээнээс мөн харагдаж байна. Тухайлбал,


- “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК-ийн хариуцсан 4 дүгээр багцад 45.08 км авто зам, 26.08 у/м төмөрбетон үүр 1 ширхэг, 44 цэгт ус зайлцуулах хоолой барих ажлуудыг тус компани 11.7 сая ам.доллароор гүйцэтгэхээр гэрээ байгуулсан байна.
- Харин 3 дугаар хэсгийг хариуцсан компани 64 цэгт ус зайлцуулах хоолойтой, төмөрбетон үүр төлөвлөгдөөгүй, 45.74 км авто замыг 14.4 сая ам.доллароор гүйцэтгэхээр гэрээ байгуулсан үзэхэд талууд гэрээний үнийг зөвшилцэн тогтоохдоо батлагдсан жишиг үнэ тарифыг хэрхэн баримталсан нь тодорхойгүй байна.

2.40 Тус компани зөвлөх, захиалаагч нарт албан бичгээр хандаж гэрээний хугацааг сунгах, үнийн дүнг нэмэгдүүлэх хүсэлт гаргажээ. Ингэхдээ гэрээний 20.1 дэх хэсэгт “гүйцэтгэгч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ямар нэгэн нэмэлт төлбөр авах, ажлын хугацааг

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

сунгах эрхтэй гэж үзэж байгаа бол шалтгааныг дурдсан мэдэгдлийг захиалагчийн инженерт өгнө” гэсний дагуу гэрээнд заасан хугацаанд мэдэгдэл ирүүлээгүй байна.

График 3. “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК-д олгосон санхүүжилтийн мэдээлэл



Эх сурвалж: ЗТХЯ-аас 2020.11.01-ний байдлаар гаргасан санхүүжилтийн мэдээ тайлан

Хүснэгт 10. “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК-ны гэрээний хэрэгжилтийн байдал

Гүйцэтгэгч байгууллага	Санхүүжилт огноо	Олгосон санхүүжилтийн хувь		Санхүүжилтийн үлдэгдэл	Гүйцэтгээгүй ажлын хувь
		Урьдчилгаа төлбөрийн	Гэрээний үнийн		
“Чайна стэйт Шинжиан констракшн” Багц 2	2019.10.31	20.0	8.6	71.3	90.6
“Чайна стэйт Шинжиан констракшн” Багц 4	2019.10.31	20.0	4.8	75.2	94.7

Эх сурвалж: ЗТХЯ-аас 2020 оны 11 дүгээр сарын 1 байдлаар гаргасан санхүүжилтийн мэдээ тайлан

2.41 “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК 2 дугаар багцын гэрээт ажлын гүйцэтгэхдээ 2.7 сая ам.доллар, 4 дүгээр багцад 2.3 сая ам.долларын урьдчилгаа төлбөрийн баталгааг ХААН банкаар дамжуулан гаргасан бөгөөд баталгааны хүчинтэй хугацаа 2020 оны 7 дугаар сарын 30-ны өдөр дуусжээ.

2.42 Иймд төслийн захиалагч ЗТХЯ-нд “Чайна стэйт Шинжиан констракшн” ХХК-ийн хариуцан ажиллаж байсан 2, 4 дүгээр багцын нийт 90.5 км замын гүйцэтгэсэн ба үлдэгдэл ажлын тоо хэмжээ, санхүүжилтийн судалгаа тооцоог гаргаж, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлыг 2021 оны зам барилгын бэлтгэл ажил эхлэхээс өмнө зохион байгуулах, гэрээ цуцлагдах болсон шалтгаан, үр дагаврыг тодорхойлж шаардлагатай арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

2.43 Барилга угсралтын гэрээний өрөнхий нөхцөлийн 4.21 дэх хэсэгт гүйцэтгэгч компани ажлын гүйцэтгэл, явцын тайлан мэдээгээ гаргах хугацаа, түүнд тусгах арга хэмжээ, захиалагч зөвлөх байгууллагад хүргүүлж танилцуулах чиг үүргийг заажээ.

2.44 Харин 5 дугаар багцын гүйцэтгэгч “Чайна жео инженеринг” ХХК гэрээгээр хүлээсэн дээрх чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй барилга угсралтын ажлын гүйцэтгэл, мэдээ тайланг 2020 оны 7, 8, 9, 10 дугаар сар буюу 3 дугаар улирлын байдлаар гаргаагүй, захиалагч зөвлөх байгууллагаас ажлын явцын мэдээ тайланг гаргуулж, хянах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- Ажлын талбай дээрх үйлдвэрлэл, бараа материалын худалдан авалт, таталт, лабораторийн туршилт, шинжилгээний ажил түүний дүгнэлт, барилга угсралтын ажлын явц үр дун, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, байгаль орчин, цаг агаарын нөхцөл байдал зэргийг нэгтгэн тусгасан гүйцэтгэгчийн баримт бичиг ажлын байранд байхгүй, хариуцан ажиллаж байгаа инженер техникийн ажилчдын тоо цөөн байна.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

2.45 Барилга угсралтын ажлын явцын тайлан мэдээг гэрээний хугацаанд захиалагч, зөвлөх байгууллагуудад хүргүүлэгүй дээрх зөрчил “Чайна жео инженеринг” ХХК-аас гадна 1 болон 3 дугаар багцын гүйцэтгэгч “Хейлонжиан женэй роуд энд бридж” ХХК, “Гүйжэу хайвэй инженеринг групп” ХХК-ийн үйл ажиллагаанд гарсантай холбоотой эдгээр компаниуд гэрээний тусгай нөхцөлийн 4.21²⁰-д заасны дагуу тус бүр 2,500 ам.доллар нийт 7,500 ам.долларын торгуулийн төлбөр төлсөн байна.

2.46 Цаашид барилгын ажлыг үргэлжлүүлэх шатанд захиалагч, зөвлөх, ТХН-ийн ИТА нар, гүйцэтгэгч компаниудаас сар бүр ирүүлж буй санхүүжилтийн хүсэлтийг тухайн сарын ажлын тайлан, мэдээний хамтаар хүлээн авч гүйцэтгэгч нар гэрээний ерөнхий тусгай нөхцөлийн 4.21-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй тохиолдолд санхүүжилтийн хүсэлтийг буцаах хүртэл арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2.47 Захиалагч ЗТХЯ, “Интерконтинентал Консалтантс энд Технократс” компанийн хооронд байгуулсан гэрээнд зам барилгын ажлын хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх стандартыг тусгасан ба “зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтийн холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэхэд захиалагчийн зөвлөгч байна” гэсний дагуу дээр дурдагдсан зөрчилтэй асуудлуудаар зөвлөхөөс захиалагчид хандаж холбогдох тайлбаруудыг хүргүүлж байсан ч захиалагч холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэгүй байна. Тухайлбал,

- Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдсанаар гүйцэтгэгч компаниуд ажлын зураг гаргах, түүний дагуу гүйцэтгэх ажлын график төлөвлөгөө, аргачлал, чанарын хяналтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, ажиллах хүч, машин, тоног төхөөрөмж, материалын зөвшөөрлийг авч ажлын талбайд төвлөрүүлэх, бэлдэх зэрэг ажлуудыг гэрээний дагуу хийж гүйцэтгэх ажлууд дээр хугацаа их алдаж байгаа талаар зөвлөх багийн ИТА нараас захиалагчид тайлбар хүргүүлж байсан боловч захиалагч тал албан ёсоор хүлээн авч, ач холбоодол өгч ажиллаагүй гэж тус багас хүргүүлсэн тайлбар бичигт дурдажээ.

2.48 Захиалагч ЗТХЯ “Интерконтинентал Консалтантс энд Технократс” ХХК-ийн хооронд байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан “Ажлын даалгавар”-ын биелэлтийн талаар ТХН, зөвлөхийн ажлын тайлан мэдээнд тусгагдаагүй байна. Захиалагч, зөвлөх байгууллагууд “Ажлын даалгавар”-ын биелэлтийг хэрхэн гаргах, дүгнэх нь тодорхой бус 2020 оны 11 дүгээр сарын байдлаар гэрээ дүгнэх ажил хийгдээгүй байна.

2.49 “Интерконтинентал Консалтантс энд Технократс” ХХК-д зөвлөх үйлчилгээний гэрээний үнэ 4.3 сая ам.долларын 41.5 хувь буюу 1.8 сая ам.долларын санхүүжилтийг олгосон байна. Харин зөвлөх багийн ИТА нар авто замын барилга угсралтын ажилд өдөр тутмын хяналт хэрэгжүүлэхдээ техник, технологийн горим зөрчигдөж байгаа асуудлууд дээр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй, захиалагчаас гүйцэтгэгч компаниудад өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажилласан нь чанаргүй ажил гүйцэтгэхэд хүрчээ.

2.50 Цаашид барилга угсралтын үе шатны ажилд гарсан шаардлага хангагүй ажлуудыг технологийн дагуу засварлах, үлдэгдэл ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийн тулд захиалагч ЗТХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгж, гүйцэтгэгч компанийн ИТА наратай ажлын уялдаа холбоотой ажиллаж, гэрээт ажлыг бүрэн хэрэгжүүлж дуусгах чиглэлээр зөвлөх компанийн зүгээс үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Зам, барилгын ажлыг 2020 оны 2 дугаар улиралд эхлүүлэхээр төлөвлөсөн боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хугацаандaa хэрэгжээгүй байна

2.51 “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажлын үндсэн 4 гүйцэтгэгч компани 2019 онд дотоодын 24 туслан гүйцэтгэгчийн 1144 ажилтан, 627 техник, тоног төхөөрөмжтэйгөөр нийт ажлын 24.6 хувийг гүйцэтгэсэн бол зарим гүйцэтгэгч компанийн ажлын зохион байгуулалтын хангалтгүй байдлаас нүүлгэн шилжүүлэлт, карьерын зөвшөөрөл

²⁰ Явцын тайланг хугацаа хоцорч танилцуулсан тохиолдолд хоноогт 500 ам.долларын торгуулийг /дээд хязгаар нь 2,500 ам.доллар/ эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 14.3 дэд заалтын дагуу танилцуулах дунд шатны төлбөрийн гүйцэтгэлийн дунгээс суутгана

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

авахад хугацаа их алдсан бол мөн бороотой өдрүүд олон хоногоор үргэлжилсэн зэрэг шалтгаанаар ажлын явц удааширсан байна.

2.52 Харин 2020 оны барилга угсралтын ажлыг дараах байдлаар төлөвлөж хэрэгжүүлснээр 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар нийт ажлын 48.1 хувийг гүйцэтгэсэн байна. Тухайлбал,

- 2020 оны бэлтгэл ажлыг 2 дугаар сарын 1, үндсэн ажлыг 3 дугаар сарын 20-ны өдөр эхлүүлэхээр төлөөлөгөө баталж, ажиллах хүч, тоноог төхөөрөмжийн зөвшөөрлийг шийдвэрлэсэн;
- 2019 оны барилгын хоцрогдлыг нөхөж, 2020 оны 6 сард багтаан дуусгахаар талбайд нийт 1298 гадаад, 325 дотоод ажиллах хүч, 658 тоноог төхөөрөмжийг ажиллуулахаар тус тус төлөөлөсөн
- COVID-19 цар тахлын улмаас хил гаалиар нэвтрэх ачаа, зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 1 дүгээр сараас зогсоо шийдвэр гарч, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан нь ажлыг эхлүүлэхэд нөлөөлжээ. Гадаадаас ажиллах хүчийг нэвтрүүлэх зөвшөөрөл авч 1,3,5 дугаар багцын ИТА нарын 26 хүнийг оруулж ажиллуулсан байна.

Зураг 4. 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар авто замын нөхцөл байдал



2.53 Зам барилгын ажлын бэлтгэл болон түр замын засварын ажлыг 2020 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс дотоодын үндсэн болон туслан гүйцэтгэгчийн Монгол ажилчдын хүчээр үе шаттай эхлүүлж 1, 3, 5 дугаар багцуудад нийт 8 туслан гүйцэтгэгч компани ажиллаж, 2020 оны 11 дугаар сарын 06-ны өдөр тус замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн байна.

2.54 “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажлын явцад дэлхий нийтээр үүсээд байгаа цар тахал нөлөөлснөөр гэрээний хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгаж, энэ хугацаанд төслийг бүрэн хэрэгжүүлж ашиглалтад оруулахаар

төлөвлөсөн боловч тухайн онд нийт ажлын 50 гаруй хувийг гүйцэтгэж чадаагүй нь 2,4 дүгээр багцын гэрээт ажил хэрэгжээгүй, гэрээ цуцлагдаж ажил зогссонтой холбоотой байна.

2.55 Эдгээр 2 багцын ажил 2019 оны жилийн эцэст 5.3-9.4 хувийн гүйцэтгэлтэй зогссон бол захиалагч ЗТХЯ 2020 оны барилга угсралтын ажлын төлөвлөгөөндөө ажлын явцыг эрчимжүүлэх, хэрхэн шийдвэрлэх арга хэмжээний талаар тусгаагүй байна.

2.56 Зөвлөх компани ажлын тайландаа гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа 2020 оны 6 дугаар сард дуусаж 8 дугаар сард цуцлахаар шийдвэрлэсэн талаар тусгаад, гүйцэтгэсэн болон үлдэгдэл ажлын тоо хэмжээг 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар гаргажээ. Харин захиалагч байгууллага тус 2 багцын ажлыг цаашид хэрхэн үргэлжлүүлэх талаар холбогдох байгууллагатай зөвшилцэж шийдвэр гаргах ажил удааширч байна. Мөн барилгын ажлын талбайд хийгдээгүй байгаа 90.6-94.7 хувийн ажлыг хэрхэн гүйцэтгэх нь тодорхой бус байна.

2.57 Иймд захиалагч ЗТХЯ нийт 5 багцын гүйцэтгэгчтэй хийсэн гэрээний хугацаанд барилга угсралтын ажил дуусгаагүй нөхцөл байдалд бодитой дүгнэлт гаргаж, хэрхэн сунгах асуудлыг шийдвэрлэх, 2,4 дүгээр багцын гүйцэтгэгч компани гэрээгээ цуцлах болсон шалтгааныг

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

тодорхойлж, тус компаниас шалтгаалж хугацаа алдсан тохиолдолд гэрээний 2.5²¹ 8.2²², 8.7²³ хэсэгт заасныг тус үндэслэн гэрээний хугацаа хоцроосон алдангийн төлбөрийг төлүүлэх шаардлагатай байна.

Түр зам барих болон төслийн бэлтгэл шатны ажлуудыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн байна

2.58 Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын шинэчлэлтийн ажлыг эхлүүлэхтэй холбоотой замын зурvas газарт орсон инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, хамгаалах, газар чөлөөлөлт зэрэг бэлтгэл үе шатанд шаардагдах 6.5 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төслийн Монголын талын хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ.

2.59 Мөн 3ТХС-ын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 380 дугаар тушаалаар мөн оны 7 сарын 3-ны өдрийн 231 дүгээр тушаалаар батлагдсан жагсаалтыг шинэчилж дээрх 6.5 тэрбум төгрөгөөр гүйцэтгэх арга хэмжээнд дараах түр замын засвар арчлалтын ажлуудыг хамруулан баталжээ.

Хүснэгт 11. Түр зам барих ажлын санхүүжилт

№	Түр зам баригдсан хэсгийн нэр	Гүйцэтгэгчийн нэр	Түр замын урт /км/	Санхүүжилтийн дун /сая төгрөг/
1	Тахилтын авто замаас-Баруун туруун	Баянчандмань А33А ХХК	5.89	156.9
2	361-ийн гаралт Баянчандмань сум	Баянчандмань А33А ХХК	27.0	155.7
3	Баянчандмань-Урьхан	Төв А33А ХХК	48.0	364.1
4	Урьхан-Баянгол сум	Булган А33А ХХК	46.4	339.9
5	Баянгол сум-Хустайн даваа	Сэлэнгэ А33А ХХК	40.0	359.0
6	Хустайн даваа-Дарханы хойд хэсэг	Дархан А33А ХХК	28.1	364.2
Нийт дун			195.4	1,739.8

Эх сурвалж: ...3ТХС-ын тушаал

2.60 “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км зам”-ын барилга угсралтын ажлыг эхлүүлсэнтэй холбоотой зорчигч болон ачаа тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, байгаль орчин, мал амьтан, хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор нийт 195.4 км түр зам барих ажлыг орон нутгийн А33А-ын компаниудтай 1.7 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

2.61 Ингэснээр 2019 оны улсын төсөвт тусгагдсан гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төслийн Монголын талын 6.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөс 4.7 тэрбум төгрөгийг эрчим хүч, төмөр зам, ус суваг, харилцаа холбоо, газар чөлөөлөлт болон зураг төслийн ажлын үлдэгдэл санхүүжилтэд зарцуулсан байна.

²¹ Хэрэв захиалагч нь өөрсдийгөө баталгаат засварын хугацааг сунгах болон гэрээтэй холбогдуулан, аль эсвэл гэрээний эдэээр нөхшилийн дагуу ямар нэгэн төлбөр нэхэмжлэх эрхтэй гэж үзэж байгаа бол захиалагч, эсвэл инженерийн аль нэг нь гүйцэтгэгчид энэ тухай мэдэгдэл өгнө;

²² Гүйцэтгэгч бүх ажлыг болон ажлын хэсэг бурийг гэрээнд заасан хугацаанд хийж дуусгахаас гадна дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

а/ ажил дуусах үед хийгдэх туршилтыг явуулах;

б/гэрээний 10.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор хийгдэх шаардлагатай ажлуудыг бүхэлд нь болон хэсэгчлэн гэрээнд заасан бүх ажлын хамт дуусгах;

²³ Хэрэв гүйцэтгэгч нь гэрээний /гэрээний ажлыг дуусгах хугацаа/ ээх 8.2 дэд заалтын дагуу ажлаа дуусгаагүй бол, гэрээний 2.5 дэд заалтын /захиалагчийн нэхэмжлэх/ дагуу захиалагчид хугацаа хоцронос алдангийг төлнө.

ДҮГНЭЛТ:

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Төрийн байгууллагууд хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд төсөл арга хэмжээний урьдчилсан тооцоо, судалгааг хийгээгүй, салбарын яам авто замын зураг төслийн зохиогчийг сонгон шалгаруулаагүй, гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгүүлсэн нь холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.
- “Улаанбаатар-Дархан чиглэлийн зам”-ыг шинэчлэх төслийн хүрээнд баригдаж буй 204.11 км авто зам, өргөтгөх төслийн хүрээнд баригдах 202.4 км авто замууд төлөвлөлт, хучилтын хийцийн хувьд өөр өөр байгаа нь цаашид замын чанар, хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.
- Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журмаар зөвхөн 1 багцын ажлыг гүйцэтгэхэд компанийн жилийн дундаж орлого 25.0 сая ам.доллар байх шалгуур тавигдсанаар зам барилгын үндэсний компаниудын хувьд сонгон шалгаруулалтад оролцох боломж хязгаарлагдсан байна.
- Гэрээний үнийн дүн батлагдсан төсөвт өртгөөс 24.5 хувиар бага, санхүүжилтийн эх үүсвэр болон гэрээний үнийн дүнгийн зөрүү 20.6 сая ам.долларыг хэрхэн зарцуулах, гэрээ цуцлагдсан 2, 4 дүгээр багцын ажлыг үргэлжлүүлэх асуудал тодорхойгүй байна.
- Тус авто замын төслийн санхүүжилтийг барилга угсралтын ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгоогүй, зөвлөх компани захиалагчийн хяналтыг чанартай хэрэгжүүлээгүй нь авто замын хучилтад гарсан эвдрэл, гүүр хоолойд хийгдэж буй засварын ажлын явцаас харагдаж байна.
- Гадаадын зээл, тусlamжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй төслийн үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүй, мөрдөгдөж буй журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна.
- Дэлхий нийтээр үүссэн цаг үеийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацааг дахин сунгасан боловч 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт ажлын 50 гаруй хувийг гүйцэтгээгүйгээс төслийг ашиглалтад оруулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “авто замын АН-3 чиглэлийн сүлжээг өргөтгөх” зорилт, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасан “үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” зорилтот хөтөлбөртэй нийцүүлэн, гадаадын зээл, тусlamжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй авто замуудын төсөлд үндэсний компаниудыг оролцуулах замаар хүчин чадал, чадавхыг сайжруулах арга хэмжээний бодлого, төлөвлөлтийг баталж, мөрдүүлэх.

Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/-д

- Авто замын салбарт үйл ажиллагаа явуулдаг үндэсний зам барилгын компаниудын чадавхыг сайжруулах чиглэлийн арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн төлөвлөж, зохион байгуулах;
- Төслийн 1, 2 дугаар шатны өргөтгөл, шинэчлэлтийн ажлын хүрээнд баригдах замыг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахуйц түвшинд гүйцэтгүүлж, техникийн шаардлагад нийцээгүй ажлуудыг засварлуулж, зам барилгын ажлын чанарт анхаарах ажлыг зохион байгуулах;
- “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг шинэчлэх төслийн санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл, мөн буцалтгүй тусlamжийн хөрөнгийг тус замын барилгын ажлын чанарыг сайжруулах арга хэмжээнд зарцуулах, уг ажлын судалгаа тооцоо, төлөвлөлтийг боловсруулан батлуулж, төслийг ашиглалтад оруулахаас өмнө хэрэгжүүлэх, зарцуулалтыг тайлагнах;
- Төслийн удирдах хорооны журамд заасан чиг үүргийг гүйцэтгүүлэх, төслийн явцыг удирдан чиглүүлэх, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, ажлын тайланг хэлэлцэн дүгнэх, биелэлтэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх;
- Төслийн 2, 4 дүгээр багцын гүйцэтгэгч компани гэрээг цуцлах болсон шалтгааныг тодорхойлж, тус компаниас шалтгаалж хугацаа алдсан тохиолдолд гэрээний холбогдох заалтад үндэслэн хугацаа хоцроосны алдангийн төлбөрийг тооцож төлүүлэх.

"Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл"-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

14251 Улаанбаатар хот.
Сүхбаатар дүүрэг, Чингисийн врэнч чөлөө 11.
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315.
E-mail: info@mnd.gov.mn, http://www.mnd.gov.mn

2021-01-26 № 01/349
таний 2021-01-18-ны № 01/261 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
О.ТЭНГИС ТАНАА

"Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км автозамын төсөл"-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар заалтад үндэслэн тус тайлангийн төсөлд холбогдох саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: хуудастай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ *Khatal* Л.ХАЛТАР

080102

"Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл"-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Зам, тээврийн хөвөгийн яамны 2021 оны
01 дугаар сарын 16-ийн 14:49
дугаар албан бичгийн хаасралт

**"Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл"-ийн
хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд хүргүүлэх санал"**

Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.5 км авто зам төсөл"-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд дараах санал байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны "Аудитын сэдэв батлах тухай" 05 дугаар тогтоолоор "Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төслийн хэрэгжилт, үр дун" гэж аудитын сэдэв тодорхойлогдсонд үндэслэн, гүйцэтгэлийн аудитын тайлангийн нэр "Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто зам барих төслийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан" гэж тодорхойлогджээ. Зам, тээврийн хөгжлийн яаманд тус нартэй төсөл хэрэгжээгүй байгаад дүгнэлт хийж, тайлангийн төслийн "Ерөнхий мэдээлэл" хэсэгт төсөл, арга хэмжээний нэршилд тайлбар, тодотгол хийж "Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажил" гэж нэрлэх саналтай байна.

1. Тайлангийн төсөлд тусгагдсан төслийн үндэслэл, төслийг хэрэгжүүлэх бодлого чиглэл, суурь судалгаа, зураг төсөлтэй холбогдох асуудалд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замд их засвар, шинэчлэлт хийхээр тусгагдсан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангах хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам нь 2016 оноос эхлэн тус замын их засвар, шинэчлэлтийн ажлын зураг төслийг боловсруулах, зам барилгын ажлыг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Авто замын бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх хүрээнд /улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлах боломжгүй байсан/ авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг концессын гарзэгээр хэрэгжүүлэхээр Терийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор тусгасан.

Үг тогтоолоор баталсан Терийн өмчийн концессийн зүйлийн жагсаалтад "Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км замыг 4 згнээтэй цемент бетон хучилттай 1 дугаар зэргийн авто зам болгон өргөтгэн шинэчлэх төсөл"-ийг концессын зүйлийн "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлөөр; концессын гэрээний хүрээнд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээг "хатуу хучилттай авто замын техник, здийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх" гэж заасан.

Энэхүү концессийн зорилтын хүрээнд аудитын тайлангийн төсөлд тусгагдсан авто замын анхны зураг төсөл гэж нэрлэгдэж буй "Эм Си Пи Си жи ар" ХХК-ийн боловсруулсан 4 згнээ цементбетон хучилттай авто замын зураг төсөл

"Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл"-ийн хэрэгжилт, үр дунд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

боловсруулагдсан байна. /Зураг төслөвөр нийт 550 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай тооцоо гарсан/.

Зам барилгын ажлын хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр шийдвэрлэх бус гадаад хөрөнгө оруулагч байгууллагын эзэл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хөргүүлэх боломжийг зэрэхийлж, Зам, тээврийн хөгжлийн яам нь АХБ-ны ТА-8852 МОН Техник туслалцааны хүрээнд хэрэгжсэн "Бус нутгийн авто замыг хөгжүүлэх, засвар арчлалтын тесел"-ийн хүрээнд тус чиглэлийн авто замын судалгааны ажлыг хамруулан, судалгаат 2016-2017 онд буюу 2 жилийн хугацаанд АХБ-ны судалгааны баг гарч судалж эцсийн тайланг боловсруулсан.

Тус судалгааны үр дунд үндэслэн АХБ-аас Улаанбаатар-Дархан чиглэлд ашиглагдаж байсан 2 эгнээ авто замыг шинэчлэхэд шаардлагатай хөнгөлөлттэй эзэл олгох шийдвэр гарсан ба үүний дунд өртөг өндөр хөрөнгө оруулалт болох Концессийн гэрээгээр хөргүүлэх шийдвэрийг Засгийн газрын тогтоолоор хүчингүй болгосон.

Ийнхүү АХБ-ны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр "Бус нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын тесел"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км ашиглагдаж байгаа авто замыг өргөтгэн шинэчлэхээр шийдвэрлэж, зээлийн гэрээг 2017 оны 07 дугаар сарын 23, 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр тус тус байгуулан зам барилгын ажлыг 2019 оны 06 дугаар сард эхлүүлсэн.

Гэтэл төслийн хүрээнд ашиглагдаж байгаа авто замд их засвар, шинэчлэлт хийхээр төлөвлөсөн байсан ба тус замын ашиглалтын нөхцөл байдал, хэтийн эрэлт хэрэгцээ, шаардлагад үндэслэн ашиглагдаж байсан 2 эгнээ авто замыг Засгийн газрын 2018 оны 284 дүгээр тогтоолоор Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгэн шинэчлэх шийдвэр гарсан.

Тус шийдвэрийн хэрэгжилтийг 1. Ашиглагдаж байсан 2 эгнээ авто замыг АХБ-ны "Бус нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын тесел"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгэл, шинэчлэлтийн ажлын дагуу, 2. Европийн сэргээн босголт, хөгжлийн банкны "Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгэл тесел"-ийн хүрээнд шинээр нэмж 202.4 км 2 эгнээ авто зам барих замаар хангаж байгаа болно.

2. Түүнчлэн аудитын тайлангийн төсөлд тусгагдсан АХБ-ны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжих буй "Бус нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын тесел"-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгэл, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үйл ажиллагаа, барилгын ажлын хэрэгжилт, төслийн удирдлага зохион байгуулалтгүй холбогдуулан дараах тайлбар байна. Үүнд:

- Аудитын тайлангийн төсөлд зам барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад тавигдах санхүүгийн шалгуур дотоодын компаниудын тендерт оролцох боломжийг хязгаарласан гэж дүгнэжээ.

Гэтэл Монгол Улсын Засгийн газраас АХБ-тай байгуулсан зээлийн гэрээнд зээлийн хөрөнгөөр хөргүүлэх худалдан авалтад АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмыг мөрдлөгө болгосон бөгөөд тус журмыг үндэслэн сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд холбогдох томъёогоор тодорхойлогдсон.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Захиалагч тус журмыг зерчихгүй байх үүрэг хүлээсэн бегаад журам нь АХБ-аас хөрөнгө оруулж байгаа бусад бүх улс орнууд нэгэн адил дагаж мөрдөг болно.

- Аудитын тайлангийн төсөлд зам барилгын ажлыг батлагдсан төсвөөр 83.4 сая амдоллараар хийж гүйцэтгэхээр байсан боловч 62.9 сая амдоллараар буюу батлагдсан төсвийг 20.5 сая амдоллороо бууруулж зам барилгын ажлын гэрээг байгуулсан ба энэ нь гэрээт ажлыг үр ашигтай хэрэгжих нөхцөлийг хангаагүй гэж дурджээ.

Гэвч Тендерийн баримт бичгийн салшгүй хэсгүүд нь тухайн зам барилгын ажлын гэрээний төсөл, зураг төсөл, техникийн шаардлага байдал ба тендерт оролцогч нь тендерийн баримт бичигт заасан гэрээ, зураг төсөл, техникийн шаардлагын хүрээнд тус ажлыг гүйцэтгэх үнийн саналаа ируулдэг.

Тендерийн үнэлгээний хороо холбогдох журмын дагуу тендерт оролцогчдын техникийн саналуудыг үнэлэн, техникийн саналын шаардлага хангасан оролцогчдийг үнийн саналаар жагсааж, техникийн шаардлагaa хангасан хамгийн бага үнийн санал ирүүлсэн тендерийг сайн үнэлэгдсэн тендер гэж тодорхойлж, санал болгосон үнийн дунгзэр гэрээ байгуулдаг ба захиалагчаас зураг теслеер тогтоосон үнийн дунгзэр гэрээ байгуулахыг шаардах эрх зүйн үндэслэл байхгүй болно.

- Багц 1-2 болон Багц 1-4 хэсэгт шалгарсан компани нь АХБ-ны худалдан авах ажиллагааны журам, тендерийн баримт бичигт заасан гэрээ хэрэгжүүлэх чадварын шаардлагуудыг бүрэн хангасан боловч тендерт ирүүлсэн үнийн санал батлагдсан төсөвт өртгөөс 20-25% орчим бага байсан. Тендерийн үнийн дүн төсөвт өртгөөс бага байсан тул гэрээт ажлын эрсдэлийг хаах зорилгоор гүйцэтгэлийн баталгааг 5%-иар өсгэж гэрээний үнийн дунгийн 10%-тай тэнцуу гүйцэтгэлийн баталгааг багц тус бүр дээр гаргуулсан.
- Зам барилгын ажлыг 5 багц хэсгээр 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдөр эхлүүлсэн ба гэрээгээр 12 сарын хугацаанд буюу 2020 оны 06 дугаар сарын 21-нд дуусах ёстой байсан. 2019 онд барилгын ажлын хэрэгжилтэд гүйцэтгэгч байгууллагын удирдлага зохион байгуулалт, менежмент хангалтгүй байдал нелээлний дээр, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал /үргэлжилсэн бороо усны улмаас нийт 28 хоног технологи үйл ажиллагаа хэрэгжээгүй/, карьерын зөвшөөрөл хугацаа алдаж гарсан (зарим карьерын байршил нь усны урсац бүрэлдэх эх хилийн заагтай давхцалтай шалтгаанаар зөвшөөрөл олгогдоогүй) зэрэг хүчин зүйлс нелээлсэн.

2020 оны зам барилгын ажлыг 2019 оны барилгын ажлын хоцрогдлыг нөхөх хүрээнд 02 дугаар сард эхлүүлэхээр, нийт 1298 гадаад ажиллах хүч ажиллуулахаар тус тус төлөвлөн холбогдох зохион байгуулалт арга хэмжээг авч ажилласан боловч дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас гадаад ажиллах хүч төлөвлөсөн хугацаанд Монгол Улсад орж ирэх боломжгүй болж барилгын ажилд ихээхэн саад учруулсан.

Цар тахлын улмаас тогтоосон хорио цээрийн дэглэмээс шалтгаалан эхний ээлжийн гадаад ажиллах хүч 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсад орж ирж 21 хоног тусгаарлагдсаны дунд 2019 он 07 дугаар сарын 29-ний өдрөөс ажлын талбайд гарч ажиллах нөхцөл бурдсан.

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

Гадаад ажиллах хүч орж ирэх хүртэлх хугацаанд барилгын ажлыг хэрэгжилтийг хангах хүрээнд захиалагчаас гүйцэтгэгч байгууллагад удаа дараа шаардлага тавьсны дунд Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 хэсгийн ажлыг дотоодын туслан гүйцэтгэгч байгууллагуудаар 2020 оны 04 дүгээр сараас барилгын ажлыг эхлүүлсэн. Зам барилгын гадаад ажиллах хүч орж ирснээр 08 дугаар сараас эрчимжсэн. Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд үндэслэн зам барилгын ажлын гэрзэг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийт хүртэлх хугацаагаар сунгах АХБ-ны зөвшөөрлийг үндэслэн Багц 1-1, Багц 1-3, Багц 1-5 хэсгийн гэрзэг сунгасан.

Зам барилгын ажлын 2020 оны график, төлөвлөгөөний хэрэгжилтэд Ковид -19 цар тахлын нөхцөл байдал сергеөөр нөлөөлсний дээр цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан багц хэсгүүдэд 48-53 хоног технологи үйл ажиллагаа хэрэгжээгүй болно.

- 2020 оны жилийн эцсийн байдлаар Багц 1-1 хэсэгт 85.43%, Багц 1-3 хэсэгт 69.76%, Багц 1-5 хэсэгт 70.46 %,-ийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн ба 2021 онд зам барилгын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Зам барилгын ажлын гэрзэг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгах, тус өдөрт багтаан барилгын ажлыг дуусгаагүй тохиолдолд гэрзэнд заасны дагуу алданги тооцоохор шийдвэрлэсэн.
- Багц 1-2 болон Багц 1-4 хэсгийн гүйцэтгэгч байгууллага нь БНХАУ-ын Шинжиан Уйгарын веertee засах оронд байрладаг ба тус муж улсад Ковид-19 цар тахлын улмаас тогтоосон хатуу хорио цээрийн дэглэмээс шалтгаалж гадаад ажиллах хүчээ Монгол Улсад оруулж ирэхэд хүндрэлтэй болсон шалтгаанаар гэрзэг цуцлах хүснэгтээ 2020 оны 08 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн.

Захиалагч гэрзэг цуцлах хүснэгтийг хулээн авч, гэрзэг 2020 оны 08 дугаар сарын 16-ны цуцалсан. Гэрзэнд заасны дагуу гэрзэ цуцлагдахтай холбогдох ажлын гүйцэтгэлийн эцсийн хэмжилтийг зөвлөх баг гүйцэтгэсэн. Үлдлэгдэл ажлын тоо хэмжээнд үндэслэн дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийн төслийг 2020 оны 12 дугаар сард боловсруулсан ба тендер зарлах хүснэгтийг АХБ-нд 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр хүргүүлж, АХБ-аас 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр авч, 01 дүгээр сарын 21-ны өдөр тендер зарласан.

- Тайланийн төсөлд Төслийн захиалагч байгууллагын удирдлага зохион байгуулалт хангалтгуйгээс барилгын ажил төлөвлөсөн хугацаанд ахижжээгүй, зам барилгын ажилд чанарын доголдол гарсан талаар дурдажээ. Захиалагч нь АХБ-тай байгуулсан эээлийн гэрээгээр хүлээсэн үүрэг, зам барилгын ажлын гүйцэтгэгч, зөвлөхийн өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж ажилласны дээр зам барилгын ажлыг эрчимжүүлэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг тухай бур авч хэрэгжүүлж ажилласан.

Харин төсөл хэрэгжүүлэх нэгжид Байгаль орчин, ниймгийн хамгааллын ажилтан авч ажиллуулах арга хэмжээний хүрээнд 2 удаа сонгон шалгаруулалт зарласан боловч шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүйгээс ажиллуулж чадаагүй. Сонгон шалгаруулалтыг дахин явуулахаар холбогдох бэлтгэл ажлыг хангаж байна.

**“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан**

- Багц 1-1 хэсэгт гүйцэтгэсэн хучилтад эвдрэл гарсан. Зам барилгын ажлын үндсэн ажил бүрэн дуусаагүй байгаа ба захиалагчаас гэрээнд заасны дагуух техникийн шаардлага хангасан авто замын ашиглалтад хүлээж авна.

Ажлын гологдолыг гэрээнд заасны дагуу гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр засварлан хүлээлгэж өгөх ёстой ба аливаа гологдол, дутагдал болон эрсдлээс сэргийлэх хүрээнд гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дунгийн 5%-иар гаруулж авсан. Гологдолыг 2021 оны барилгын ажлын хугацаанд засварлуулахаар төлөвлөсөн.

- ००० -

“Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто зам төсөл”-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналд Үндэсний аудитын газраас дараах тайлбарын өгч байна.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	УИХ-ын Төсвийн Байнгын хорооны тогтоолоор батлагдсан аудитын сэдвийг өөрчлөх боломжгүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна. Аудитын тайлангийн 1.18, 1.67-д “Бус нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км замын шинэчлэлтийн ажил гэж өөрчлөн найруулав.
Тайлбар 2	Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	Санал биш тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.